




БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК

2020 оны 12 сарын 31-ний өдрөөр
тасалбар болгосон санхүүгийн тайлан



АГУУЛГА

Санхүүгийн тайлангийн талаарх удирдлагын хариуцлагын мэдэгдэл

Хараат бус Аудиторын тайлан

Аудитлагдсан санхүүгийн тайлан

- Санхүүгийн байдлын тайлан
- Орлого үр дүн болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан
- Өмчийн өөрчлөлтийн тайлан
- Мөнгөн гүйлгээний тайлан

Санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд

- Тайлагнагчийн мэдээлэл
- Тайлан бэлтгэсэн үндэслэл
- Нягтлан бодох бүртгэлийн гол чухал тооцоолол ба шийдэл
- Нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын хураангуй

Санхүүгийн тайлангийн тодруулгууд

Санхүүгийн хэрэглүүр-Эрсдэлийн удирдлага

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ОЧИРУНДРАА

Ажилтныг санхүүжүүлэх



Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг,
3-р хороо, Сөүлийн гудамж, Сөүл плаза, 401 тоот.
Утас: 75751818 Вэб сайт: www.omz.mn
Факс: 31 98 89 И мэйл: info@omz.mn

Додт. 02. 05 № 21/52
танай _____ ны № _____ -Т

БЭЙКЕР ТИЛИ ДАЛАЙВАН
АУДИТ ХХК-НД

2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон
жилийн санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл

“Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-ийн удирдлага бид Санхүүгийн тайлангуудаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв бэлтгэх, компанийн өмч хөрөнгийг хамгаалах, залилан бусад зөрчил дутагдлаас сэргийлэх, илрүүлэх арга хэмжээг авах үүрэгтэй.

Тайлангийн хугацааны эцэст компани үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах нөөц боломжоо үнэлж байх бөгөөд байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй гэж үнэлсэн тохиолдолд тасралтгүй байдлын талаар санхүүгийн тайландаа тусгах үүрэгтэй.

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, буюу компанийн ирээдүйн үйл ажиллагаанд алдагдал хүлээж болзошгүй зүйлсийг байнга хянаж байх үүрэгтэй бөгөөд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн тохиолдолд болзошгүй зүйлсийн талаар санхүүгийн тайландаа тайлагнах үүрэгтэй.

Бид 2020 оны 12 дугаар сарын 31-ээр тасалбар болгосон санхүүгийн тайлагналтай холбоотой дээрх үүрэг хариуцлагаа ухамсарлан санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт, Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг баримтлан үнэн зөв бэлтгэсэн гэдгээ үүгээр мэдэгдэж байна.

“Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх энэхүү тайланг хүлээн зөвшөөрч батлав.

Хүндэтгэсэн,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

НЯГТЛАН БОДОГЧ



Г.ЦОГТГЭРЭЛ

Г.БОЛОРТУЯА



БЭЙКЕР ТИЛЛИ ДАЛАЙВАН АУДИТ

Аудит, баталгаажуулалт, хөрөнгийн болон
бизнесийн үнэлгээ, зөвлөх үйлчилгээ

Монгол Улс, Улаанбаатар хот-16066
Баянгол дүүрэг, Амарсанаагийн гудамж-5
Утас: 70005401, 70005404, 70005405
Факс: +976-70005403
Э.Шуудан: info@dalaivanaudit.mn
Вэб хуудас: www.dalaivanaudit.mn

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК -ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛД

Санал дүгнэлт

Бид 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан, жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан болон ач холбогдол өндөртэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын хураангуйг багтаасан санхүүгийн тайлангийн тэмдэглэлээс бүрдсэн “Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-ийн санхүүгийн тайланд аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр “Очир Ундраа ОМЗ ББСБ” ХХК-ийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон жилийн үйл ажиллагааны орлого үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ нь бүхий л материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв илэрхийлэгдсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт (АОУС)-ын дагуу хийж гүйцэтгэсэн болно. Энэ стандартын дагуу бидний хүлээх үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн санхүүгийн тайлангийн аудитад аудиторын хүлээх үүрэг хариуцлага хэсэгт харуулсан. Бид санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу үйлчлүүлэгчээс хараат бус байх, эдгээр шаардлагуудын дагуу ёс зүйн бусад үүрэг хариуцлагуудыг мөрдөж ажилласан.

Бидний олж авсан аудитын нотолгоо нь аудиторын санал дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой гэж үзэж байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд нь бидний мэргэжлийн шийдлээр тайлант хугацааны санхүүгийн тайланд хийсэн бидний аудитад хамгийн их анхаарал татсан асуудал байдаг. Харин бидний гаргасан тайланд материаллаг хэмжээний аудитын гол асуудал байхгүй хэмээн тодорхойлж байна.

Бусад мэдээлэл

Удирдлага бусад мэдээллийн хувьд хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрддэг боловч түүнд санхүүгийн тайлан болон аудиторын тайлан багтаагүй байдаг. Бидний санхүүгийн тайланд өгсөн дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй ба бид уг мэдээлэлд аливаа баталгаа илэрхийлээгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттай холбоотойгоор бид бусад мэдээллийг унших үүрэгтэй учраас уг мэдээлэл нь санхүүгийн тайлантай материаллаг байдлын хувьд нийцэж байгаа эсэхийг авч үзнэ. Хэрэв бид хийсэн ажилдаа үндэслэн бусад мэдээлэлд материаллаг буруу тайлагнал байна гэж дүгнэсэн бол энэ байдлыг тайландаа тусгах ёстой. Аудитын явцад бид энэ талаар тайлагнах шаардлага үүсээгүй.

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн талаар удирдлага болон засаглах удирдлагын хүлээх хариуцлага

Удирдлага нь СТОУС-ын дагуу санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах үүрэг хүлээхээс гадна залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэхэд зайлшгүй чухал гэж тодорхойлсон дотоод хяналтуудыг тодорхойлно.

Санхүүгийн тайланг бэлтгэхдээ удирдлага компанийн үйл ажиллагааг төлбөрийн чадваргүй болох эсвэл үйл ажиллагаагаа зогсоох, ингэхээс өөр сонголтгүй байхаас бусад тохиолдолд удирдлага санхүүгийн тайлангаа тасралтгүй байх зарчмын дагуу үйл ажиллагаагаа зогсолтгүй явуулах компанийн чадамжийг үнэлэх хариуцлагыг хүлээх ба тасралтгүй байдалтай холбоотой асуудлууд болон нягтлан бодох бүртгэлд ашигласан тасралтгүй байдлын суурийн талаар нэмэлт тодруулга хийнэ.

Компанийн засаглах удирдлага нь санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүргийг хүлээнэ.

Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх хариуцлага

Бидний зорилго бол санхүүгийн тайлан нь бүхэлдээ залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагналгүй бэлтгэгдсэн эсэх талаар хамгийн боломжит баталгааг олж авах, өөрийн дүгнэлтийг илэрхийлсэн аудиторын тайланг бэлтгэх явдал юм. Хамгийн боломжит баталгаа гэдэг нь дээд түвшний баталгаа боловч АОУС-ын дагуу хийж гүйцэтгэсэн аудит нь оршин байгаа буруу тайлагнал бүрийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгааг өгөхгүй юм. Залилан эсвэл алдаанаас шалтгаалан буруу тайлагнал үүсэж болох ба дангаараа эсвэл нийтдээ материаллаг гэж үзсэн бол санхүүгийн тайланд тулгуурлан хэрэглэгчийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх боломжтой юм.

АОУС-ын дагуу бид аудитын туршид мэргэжлийн үл итгэх хандлагыг баримтлан мэргэжлийн шийдэл гаргаж ажилласан. Мөн бид:

- ✓ Санхүүгийн тайланд залилан эсвэл алдаанаас үүдэх материаллаг алдаатай тайлагнал байх эрсдэлийг тодорхойлж үнэлсэн, тэдгээр эрсдэлүүдэд хариу аудитын горимуудыг тодорхойлж хэрэгжүүлсэн, мөн дүгнэлтийн үндэслэл болох аудитын хангалттай нотолгоог олж авсан. Гэхдээ алдаанаас бус үгсэн хуйвалдсан үйл ажиллагаа, хуурамчаар үйлдэх, санаатай орхигдуулах, дотоод хяналтыг үл хэрэгсэх эсвэл гуйвуулах зэрэг залилангаа шалтгаалсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлтэй.
- ✓ Аудитын зохистой горимыг боловсруулахын тулд байгууллагын дотоод хяналтын тогтолцооны талаар ойлголт олж авсан, гэхдээ дотоод хяналтын үр дүнтэй байдалд дүгнэлт өгөх зорилгогүй.
- ✓ Компанийн ашиглаж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, удирдлагын хийсэн тооцоолол болон тодруулгын зохистой байдлыг үнэлсэн.
- ✓ Хэрэв байгууллагын тасралтгүй байх чадавхид материаллаг тодорхойгүй байдал байна гэж үзвэл бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгын хэсэгт бид анхаарлаа хандуулах болно. Хэрэв энэ талаар холбогдох тодруулгад хангалттай дурдаагүй байвал бид аудитын дүгнэлтээ өөрчлөх болно. Бидний өгөх аудитын дүгнэлт нь аудиторын тайланг огноолох өдөр хүртэлх аудитын нотолгоонд суурилна. Иймд байгууллагын тасралтгүй байх чадварт нөлөөлөх нөхцөл байдал ирээдүйд үүсэж болох юм.
- ✓ Санхүүгийн тайлангийн бүтэц, агуулга, толилуулга болон тодруулгыг бид бүхэлд нь шалгаж санхүүгийн тайлан нь ажил гүйлгээ ба үйл явдлыг үнэн зөв харуулсан эсэхийг үнэлсэн.

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Бид засаглах удирдлагатай аудитын цар хүрээ, хугацаа, бусад хамааралтай асуудлуудаас гадна аудитаар илэрсэн томоохон чухал асуудлууд болон аудитын явцад ажиглагдсан дотоод хяналтын сул талуудын талаар харилцсан.

Мөн бид засаглах удирдлагад аудиторын хараат бус байдлын талаар холбогдох ёс зүйн шаардлагуудыг мэдэгдсэн бөгөөд бидний хараат бус байдалд нөлөөлж болохуйц аливаа харилцаа холбоо, түүнээс сэргийлэх арга хэмжээнүүд болон бусад асуудлуудын талаар ярилцсан.

Засаглах удирдлагатай харилцсаны үндсэн дээр бид тайлант хугацааны санхүүгийн тайлангийн аудитаар хамгийн чухал гэж авч үзсэн асуудлуудыг тодорхойлж аудитын гол асуудлууд гэж үзсэн. Бид олон нийтэд мэдээллэх нь сөрөг үр дагаврыг авчрах учраас хууль тогтоомжоор хориглосон байдаг асуудлаас бусад аудитын асуудлуудыг аудиторын тайландаа харуулсан.

Бусад

Энэхүү тайланг Компанийн тухай хуулийн 94-р зүйлд заасны дагуу компанийн хувьцаа эзэмшигчид зориулан бэлтгэсэн ба бид тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



УЛААНБААТАР ХОТ

БЭЙКЕР ТҮГҮЙ ДАЛАЙВАН АУДИТ ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2018365 СТА21

2021 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 04-НИЙ ӨДӨР

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Аудитлагдсан санхүүгийн тайлан**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

	Тодруулга	2020.12.31. мянган төгрөг	2019.12.31. мянган төгрөг
ХӨРӨНГӨ			
<u>Эргэлтийн хөрөнгө</u>			
Мөнгөн хөрөнгө	6.1.	9,396,151.2	1,210,084.9
Зээл /цэвэр/	6.2.	21,119,560.5	28,722,977.8
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	6.2.	1,278,642.3	387,241.3
Бусад авлага	6.6.	50,979.7	7,970.7
Бусад хөрөнгө	6.6.	139,686.0	285,164.6
Эргэлтийн хөрөнгийн дүн		31,985,019.7	30,613,439.3
<u>Эргэлтийн бус хөрөнгө</u>			
Үндсэн хөрөнгө (цэвэр)	6.7.	2,134,959.1	1,911,265.0
Биет бус хөрөнгө (цэвэр)	6.8.	99,484.1	80,391.7
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	6.9.	684,000.0	684,000.0
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		2,918,443.2	2,675,656.7
НИЙТ ХӨРӨНГӨ		34,903,462.9	33,289,096.0
ЭХ ҮҮСВЭР			
<u>ӨР ТӨЛБӨР</u>			
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	6.3.		4,140,765.5
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	6.4.	8,086,856.2	6,509,370.0
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг	6.5.	476,377.2	359,058.6
Бусад өглөг	6.10.	377,979.6	207,934.0
Богино хугацаат өр төлбөрийн дүн		8,941,213.0	11,217,128.1
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээл	6.3.		470,000.0
Урт хугацаат өр төлбөрийн дүн			470,000.0
Өр төлбөрийн дүн		8,941,213.0	11,687,128.1
<u>Өөрийн хөрөнгө</u>			
Энгийн хувьцаа	6.11.	2,500,000.0	2,500,000.0
Нэмж төлөгдсөн капитал	6.11.	684,000.0	684,000.0
Нийгмийн хөгжлийн сан	6.11.	30,990.9	25,244.7
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	6.11.	22,747,259.0	18,392,723.1
Өөрийн хөрөнгийн дүн		25,962,249.9	21,601,967.8
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ӨӨРИЙН ХӨРӨНГӨ		34,903,462.9	33,289,096.0

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Аудитлагдсан санхүүгийн тайлан**ОРЛОГО ҮР ДҮН БОЛОН**
БУСАД ДЭЛГЭРЭНГҮЙ ОРЛОГЫН ТАЙЛАН

Үзүүлэлт	Тодруулга	2020.12.31. мянган төгрөг	2019.12.31. мянган төгрөг
Хүү болон түүнтэй адилтгах орлого	6.12.	8,456,572.8	8,129,025.4
Хүүний зардал	6.13.	(347,871.2)	(707,288.2)
<i>Цэвэр хүүний орлого</i>		8,108,701.6	7,421,737.2
Хүүний бус орлого	6.14.	133,694.4	114,447.4
<i>Хүүний бус зардал:</i>			
Ханшийн зөрүүний алдагдал	6.15.	(611.3)	(209.1)
Боловсон хүчинтэй холбоотой зардал	6.15.	(979,677.9)	(897,190.7)
Үйл ажиллагааны бусад зардал	6.15.	(1,884,400.9)	(1,628,647.7)
Эрсдэлийн сангийн зардал	6.15.	(646,870.6)	(810,188.8)
<i>Үйл ажиллагааны ашиг</i>		4,730,835.2	4,199,948.3
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	6.16.	135,770.2	44,686.3
Үндсэн бус үйл ажиллагааны зардал	6.16.	(6,760.7)	(3,718.8)
<i>Татварын өмнөх ашиг (алдагдал)</i>		4,859,844.8	4,240,915.8
Орлогын албан татварын зардал	6.17.	(480,769.5)	(602,950.6)
<i>Тайлант жилийн татварын дараах ашиг</i>		4,379,075.3	3,637,965.2
<i>Бусад дэлгэрэнгүй орлого:</i>			
Эрсдэлийн сангийн нөөцийн (өсөлт), бууралт			
Нийгмийн хөгжлийн сангийн (өсөлт), бууралт	6.11.	(5,746.2)	(2,809.6)
Нийт бусад дэлгэрэнгүй орлого		4,373,329.1	3,635,155.6
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг төгрөг	6.18.	1,751,630.1	1,455,186.0

"BAKER TILLY DALAIVAN AUDIT" LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан
Аудитлагдсан санхүүгийн тайлан

ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛГИЙН ТАЙЛАН

Үзүүлэлт	Хувьцааг	Нэмж	Бусад нөөц	Хуримтлагдсан	Нийт
	мянган төгрөг	төлөгдсөн капитал мянган төгрөг	мянган төгрөг	ашиг (алдагдал) мянган төгрөг	мянган төгрөг
2018 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,500,000.0	684,000.0	28,054.3	14,771,164.2	17,983,218.5
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа Залруулагдсан үлдэгдэл Нийгмийн хөгжлийн сангийн өөрчлөлт Эрсдэлийн сангийн нөөц Тайлант үеийн цэвэр ашиг	2,500,000.0	684,000.0	28,054.3 (2,809.6)	14,771,164.2 (16,406.2)	17,983,218.5 (19,215.8)
2019 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,500,000.0	684,000.0	25,244.7	18,392,723.1	21,601,967.8
Бүртгэлийн бодлогын өөрчлөлт, алдаа Залруулагдсан үлдэгдэл Нийгмийн хөгжлийн сангийн өөрчлөлт Эрсдэлийн сангийн нөөц Тайлант үеийн цэвэр ашиг	2,500,000.0	684,000.0	25,244.7 5,746.2	18,392,723.1 (24,539.5)	21,601,967.8 (18,793.3)
2020 оны 12-р сарын 31-ээрх үлдэгдэл	2,500,000.0	684,000.0	30,990.9	22,747,259.0	25,962,249.9
				4,379,075.3	4,379,075.3

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Аудитлагдсан санхүүгийн тайлан**МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН**

	2020.12.31.	2019.12.31.
	мянган төгрөг	мянган төгрөг
1. ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1.1 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн орлого	47,966,084.9	43,193,969.1
Зээлийн хүүний орлого	6,857,189.0	5,918,731.8
Харилцах дансны хүүний орлого	930.7	2,455.0
Банкин дахь хадгаламжийн хүүний орлого	28,822.9	
Олгосон зээлийн эргэн төлөлт	34,273,310.8	32,745,748.0
Итгэлцлийн үйлчилгээний орлого	1,973,785.9	3,335,566.5
Үйлчилгээний хураамж, шимтгэлийн орлого	65,788.6	85,139.8
Бусад орлого	4,766,257.0	1,106,328.0
1.2 Үндсэн үйл ажиллагааны мөнгөн зарлага	34,978,063.6	43,361,267.0
Банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүний зардал	341,206.4	659,729.9
Төслийн зээлийн санхүүжилтийн хүүний зардал	6,664.8	15,928.6
Итгэлцлийн үйлчилгээ болон түүнтэй холбогдон гарсан мөнгө	1,179,991.5	1,820,075.2
Харилцагчдад олгосон зээл	27,251,184.4	37,265,576.0
Үндсэн ба нэмэгдэл цалин	381,565.9	583,757.5
Ажилтнуудад олгосон нөхөн олговор, тэтгэмж	4,532.9	1,848.3
Нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын зардал	40,506.8	193,607.6
Албан томилолт, сургалтын зардал	11,276.3	17,413.6
Ашиглалтын зардалд төлсөн мөнгө	29,817.1	24,597.5
Шатахуун, холбоо, интернет, сэлбэг хэрэгсэлд төлсөн мөнгө	25,361.1	31,709.0
Бичиг хэргийн зардал, ариун цэврийн зардал	4,641.6	20,662.6
Татвар, даатгалд төлсөн мөнгө	490,614.7	744,381.0
Зар сурталчилгаанд төлсөн мөнгө	35,270.3	35,270.8
Аудитын төлбөр, мэргэжлийн зөвлөгөө үйлчилгээний мөнгө	4,440.0	93,754.9
Зохицуулалтын үйлчилгээний хураамжид төлсөн мөнгө	3,240.0	3,240.0
Бусад зардал	5,167,749.8	1,849,714.5
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	12,988,021.3	(167,297.9)
2. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Хөрөнгө борлуулснаас орж ирсэн мөнгө		24,045.0
Хөрөнгө худалдан авахад төлсөн мөнгө	(190,996.2)	(202,540.0)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(190,996.2)	(178,495.0)
3. САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Бусдаас авсан зээл	19,635,607.2	32,276,700.0
Авсан зээлийн эргэн төлөлт	(24,246,372.7)	(31,520,761.9)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	(4,610,765.5)	755,938.1
Валютын ханшийн зөрүүний олз	(193.3)	91.4
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,186,066.3	410,236.6
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,210,084.9	799,848.3
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	9,396,151.2	1,210,084.9

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC

CERTIFIED ACCOUNTING, AUDITING

& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга

1. ТАЙЛАГНАГЧ АЖ АХУЙН НЭГЖ

Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК анх 2002 оны 12 дугаар сарын 23-ны өдөр Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу Хязгаарлагдмал Хариуцлагатай Компанийн хэлбэрээр үүсгэн байгуулагдаж 2734745 регистрийн дугаар бүхий 9015001102 тоот улсын бүртгэлийн гэрчилгээ авсан. 2007 оны 11 дүгээр сарын 13-ны өдөр үйл ажиллагааныхаа чиглэлийг өөрчлөн банк бус санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн.

Монгол Улсын Санхүүгийн Зохицуулах Хорооны 2008 оны 3 дугаар сарын 13-ны өдрийн 39 дүгээр тогтоолоор Банк Бус Санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн 1/222 тоот гэрчилгээ авсан. 2011 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн 53 дугаар тогтоолоор итгэлцлийн үйлчилгээний тусгай зөвшөөрөл авсан бол тайлант хугацаанд цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл нэмж авсан. Тусгай зөвшөөрлийн дагуу ББСБ дараах үйл ажиллагааг эрхэлж байна.

- Зээл
- Гадаад валют арилжаа
- Итгэлцлийн үйлчилгээ
- Цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулгын үйлчилгээ

Хамгийн өргөн хүрээтэйгээр явуулж байгаа үйл ажиллагаа нь зээлийн үйл ажиллагаа бөгөөд харилцагчиддаа дараах төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна.

- Эргэлтийн хөрөнгө барьцаалсан зээл
- Итгэлцэл барьцаалсан зээл
- Цалингийн зээл
- Авто лизингийн зээл
- Орон сууц, объект барьцаалсан судалгаатай зээл
- Хашаа байшин барьцаалсан зээл
- Автомашин унаж явах нөхцөлтэй судалгаатай зээл
- Орон сууц барьцаалсан судалгаатай зээл
- Авто машин хадгалах нөхцөлтэй зээл
- Сургалтын зээл
- Хялбар зээл
- Кредит карт

Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,500 ширхэг хувьцаанаас бүрдэх ба энгийн хувьцааг Монгол улсын иргэн Т.Гантөмөр 100% эзэмшиж байна. 2020 оны жилийн эцсийн байдлаар 42 ажилтантай, Улаанбаатар хотод дөрөв, орон нутагт нэг салбартайгаар үйл ажиллагаа явуулж байна.

Байршил:

Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 3-р хороо, Сөүлийн гудамж 20/1 компанийн өөрийн байр

Өмчийн хэлбэр:

Хязгаарлагдмал хариуцлагатай компани

Харилцагч санхүү, татварын байгууллага:

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн санхүү, татварын хэлтэс

Тайланг хамарсан хугацаа:

2020 оны 01-р сарын 01-с

2020 оны 12-р сарын 31-г дуустал

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

2. АУДИТЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

Аудитын компани:	Бэйкер Тилли Далайван Аудит ХХК
Үйл ажиллагааны зөвшөөрөл:	Аудит баталгаажуулалтын үйл ажиллагааны 22-2015 дугаар тусгай зөвшөөрөлтэй бөгөөд 2023 оны 1 дүгээр сар хүртэл сунгуулсан.
Олон улсын гишүүнчлэл:	2007 онд аудит баталгаажуулалт болон зөвлөх үйлчилгээний олон улсын сүлжээ Bakertilly International байгууллагын хараат бус гишүүн байгууллагаар элссэн.
Албан ёсны хаяг:	Компанийн өөрийн байр, Амарсанаагийн гудамж, Баянгол дүүрэг, 16 дугаар хороо, Улаанбаатар хот, Монгол улс.

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ

3.1 СТОУС-ын нийцэл

Очир Ундраа ОМЗ ББСБ ХХК-ийн санхүүгийн тайлан нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт (СТОУС)-ууд болон Санхүүгийн Тайлагналын Тайлбарын Хороо (СТГХ)-оос гаргасан тайлбарууд, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан СТОУС-ыг дагаж мөрдсөн болно.

Компанийн үйл ажиллагааны бүртгэлийн болоод тайлагналын валют нь Монгол улсын мөнгөн тэмдэгт Төгрөг байна. Эдгээр санхүүгийн тайлангууд нь Төгрөгөөр илэрхийлэгдсэн бөгөөд мянган төгрөгөөр нарийвчлан харуулж тайлагнасан.

СТОУС-ын дагуу санхүүгийн тайлан бэлтгэхэд тодорхой, чухал нягтлан бодох бүртгэлийн тооцоолол хийхийг шаарддаг. Мөн компанийн нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэглэхэд удирдлагаас шийдэл гаргахыг шаарддаг. Санхүүгийн тайлан бэлтгэхэд хийгдсэн нөлөө бүхий шийдэл ба тооцоолол, түүний нөлөөллийн талаар Санхүүгийн тайлангийн 4 дүгээр хэсэгт тодруулсан.

3.2 Хэмжилтийн үндэслэл

Эдгээр санхүүгийн тайлангууд нь доорх зүйлсээс (дэлгэрэнгүй мэдээллийг зохих нягтлан бодох бүртгэлийн бодлогоос харах) бусад зүйлсийн хувьд түүхэн өртөгт суурилан бэлтгэгдсэн.

- Санхүүгийн хэрэглүүр – Зээл ба авлага хорогдуулсан өртгөөр илэрхийлэх,
- Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө - Бодит үнэ цэнээр илэрхийлэх
- Санхүүгийн өр төлбөр – Хорогдуулсан өртгөөр илэрхийлэх

3.3 Тасралтгүй үйл ажиллагааны зарчим

Тасралтгүй байх зарчмын дагуу байгууллага өөрийн бизнесийг төсөөлж болох ирээдүйн хугацаанд үргэлжлүүлнэ гэсэн төсөөлөл дээр үндэслэн санхүүгийн тайлангаа бэлтгэнэ.

Хэрэв удирдлага байгууллагыг татан буулгах, эсвэл үйл ажиллагааг нь зогсоохоор санаархаж байгаа буюу эсвэл тэгэхээс өөр ямар ч бодит боломжгүй байхаас бусад тохиолдолд ерөнхий зорилготой санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу бэлтгэдэг. Тасралтгүй байх таамаглалыг хэрэглэх нь зохимжтой бол тухайн байгууллага бизнесийн хэвийн явцад хөрөнгөө хэрэгжүүлж, өр төлбөрөө барагдуулах боломжтой байна гэсэн үндэслэлээр хөрөнгө ба өр төлбөрийг бүртгэдэг.

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)**

3.4 Тайлангийн хугацаанд шинээр хэрэгжиж эхэлсэн стандартууд болон бусад стандартын нэмэлт өөрчлөлтүүд.

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын хүрээ	Санхүүгийн тайлагналын үзэл баримтлалуудыг дараах шинж чанаруудаар бүлэглэсэн байна. Бүлэг 1-Санхүүгийн тайлагналын зорилго Бүлэг 2- Санхүүгийн мэдээллийн хэрэгцээтэй байдлын чанарын үзүүлэлтүүд Бүлэг 3- Санхүүгийн тайлан болон тайлагнагч аж ахуйн нэгж Бүлэг 4- Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд Бүлэг 5- Хүлээн зөвшөөрөлт ба үл хүлээн зөвшөөрөлт Бүлэг 6- Хэмжилт Бүлэг 7- Толилуулга ба тодруулга Бүлэг 8- Капиталын талаарх үзэл баримтлал/ ойлголт ба капитал засвар	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх
СТОУС 3 Бизнесийн нэгдэл- Бизнесийн тодорхойлолт (2018 оны 10-р сард гарсан нэмэлт өөрчлөлт)	Бизнес гэж тодорхойлохын тулд хамгийн багадаа багц үйл ажиллагаа болон хөрөнгийг олж авсан байх, орцыг иж бүрэн процессоор оруулж гарц бий болгодог байна гэж тодотгосон. Мөн үйлчлүүлэгчид бараа болон үйлчилгээг хүргэдэг байх гэж оруулсанаас гадна өртөг зардал хэмнэх гэсэн хэсгийг хассан.	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх
НББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга, НББОУС-8 нягтлан бодох бүртгэлийн бодлого, нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт ба алдаа	Материаллаг байдлын талаарх тодорхойлолтыг нэг ижил ойлголт болгохын тулд тухайлсан нэмэлт өөрчлөлтүүдийг баталсан. Шинэ тодорхойлолтоор мэдээллийг орхигдуулсан, буруу тайлагнасан, гуйвуулсан, бүрхэгдүүлсэн нь тухайн тайлагнагч аж ахуйн нэгжийн талаарх санхүүгийн мэдээллээр хангадаг нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангуудад үндэслэн шийдвэр гаргадаг гол хэрэглэгчдийн шийдвэр гаргалтанд нөлөөлнө гэж үзэж байвал материаллаг гэж авч үзнэ.	2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

3.4 Тайлангийн хугацаанд шинээр хэрэгжиж эхэлсэн стандартууд болон бусад стандартын нэмэлт өөрчлөлтүүд. (үргэлжлэл)

СТОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
<p>СТОУС 16 Түрээс (2016 оны 01-р сард гаргасан)</p>	<p>СТОУС 16-ын гол том өөрчлөлт нь “COVID 19 цар тахалтай холбоотой түрээсийн төлбөрийн хөнгөлөлт”-г тооцох боломжтой гэсэн ерөнхий зарчмыг гаргасан.</p> <p>COVID 19 цар тахлын шууд нөлөөнөөс түрээслэгчид олгогдохоор тооцож буй түрээсийн хөнгөлөлт нь доорх нөхцөлийг хангах юм.</p> <p>-түрээсийн дахин тооцоолсон төлбөр нь хөнгөлөлт эдлэх хугацаанаас өмнө түрээсийн гэрээгээр тохирсон дүнтэй бараг ижил эсвэл түүнээс бага байх, -хөнгөлөгдсөн түрээсийн төлбөр нь 2021 оны 06-р сарын 30-ны өдрөөс өмнө түрээсийн гэрээгээр хийгдсэн түрээсийн төлбөрт хамаатай байх, -түрээсийн гэрээнд урд тусгагдсан материаллаг хэмжээний өөрчлөлтийг оруулахгүй байх,</p> <p>Түрээслэгч нь стандартаар зөвшөөрөгдсөн тухайн хөнгөлөлтийн талаарх мэдээллийг санхүүгийн тайланд тодруулах ба хөнгөлөлт үзүүлсний үр дүнд тухайн байгууллагын ашиг, алдагдалд нөлөөлөх өөрчлөлтийг толилуулах шаардлагатай байна.</p> <p>Тухайн стандартын дагуу дахин тооцоолсон хөнгөлөлтэй түрээсийн төлбөрийг СТОУС 9-н 3.3.1 дэх заалт, СТОУС 16-н 38 (b) заалт зэргийг тус тус үндэслэн хүлээн зөвшөөрөх боловч тухайн тодорхой нөхцөл байдлаас шалтгаалах юм.</p>	<p>2020 оны 06 дугаар сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэх</p>

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)**

3.5 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн жилд заавал мөрдөхөөр заагаагүй стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн, эдгээрийг хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлээгүй.

СТОУС/НББОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
СТОУС 17 Даатгалын гэрээ (2017 оны 05-р сард шинээр гаргасан)	Уг стандарт нь СТОУС 4-ийг орлох бөгөөд СТОУС 17-ийн цар хүрээнд хамаарах даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, толилуулга, тодруулгын зарчмуудыг тогтоосон. Даатгалын өр төлбөрийг өр төлбөр барагдуулахад төлөх мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ. Бүх даатгалын гэрээний хувьд нэгдсэн хэмжилтийн болон толилуулгын аргыг ашиглана. Энэ нь даатгалын гэрээнд зарчимд суурилсан бүртгэлийг тогтмол хэрэглэх боломжийг олгоно.	2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхлэх ёстой байсныг 2023 оны 01 дүгээр сарын 01-с хэрэгжүүлэхээр хойшлуулсан.
НББОУС 8 НБББодлого, НББ-н Тооцооллын өөрчлөлт ба алдаа (2019 оны 01-р сард гарсан нэмэлт өөрчлөлт)	Шинэ тодорхойлолтоор мэдээллийг орхигдуулсан, буруу тайлагнасан, гуйвуулсан, бүрхэгдүүлсэн нь тухайн тайлагнагч аж ахуйн нэгжийн талаарх санхүүгийн мэдээллээр хангадаг нийтлэг зориулалттай санхүүгийн тайлангуудад үндэслэн шийдвэр гаргадаг гол хэрэглэгчдийн шийдвэр гаргалтанд нөлөөлнө гэж үзэж байвал материаллаг гэж авч үзнэ.	2021 оны 03 дугаар сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх
НББОУС 21 Гадаад валютын ханшийн өөрчлөлтийн үр нөлөө (2020 онд гарсан нэмэлт өөрчлөлт)	Стандартын холбогдох заалтад орох нэмэлт өөрчлөлтөөр солилцоо хийх боломжийг тодорхойлж, валютын солилцоо хийгдэхгүй үед байгууллагууд валютын спот ханшийг хэрхэн тодорхойлохыг тусгахаар өөрчлөх юм байна.	2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх
НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга (2020 онд оруулсан нэмэлт өөрчлөлт)	“Өр төлбөрийг богино ба урт хугацаагаар ангилах” талаар өөрчлөлт оруулсан. Байгууллага нь тайлангийн хугацааны эцэст өр төлбөрийг урт хугацаатай гэж ангилахдаа өр төлбөрийг барагдуулах үүрэг хариуцлагыг багадаа 12 сараар хойшлуулах эрхтэй байгаа үед л хүлээн зөвшөөрөгдөхөөр тодорхой заасан байна. Уг ангилал нь дээр дурдсан эрхтэй бол хэрэгжих ба байгууллага ийм эрхээ эдлэх эсэхээс үл хамаарах юм байна.	2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

3. ТАЙЛАН БЭЛТГЭСЭН ҮНДЭСЛЭЛ (үргэлжлэл)

3.5 2020 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн жилд заавал мөрдөхөөр заагаагүй стандартууд ба тайлбарууд шинээр батлагдаж, хэвлэн нийтлэгдсэн, эдгээрийг хугацаанаас өмнө хэрэгжүүлж эхлээгүй. (үргэлжлэл)

СТОУС/НББОУС	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийн гол агуулга	Хэрэгжих огноо
<p>СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан ба СТОУС 11 Хамтын хэлэлцээр СТОУС 12 Бусад ААН-д дэх хувь оролцооны тодруулга гэсэн стандартуудад оруулах өөрчлөлт</p>	<p>Дэлхий дахинд тархаад байгаа Covid 19 цар тахлын үед эдгээр стандартуудын хэр үр өгөөжтэй хэрэгжиж байгаа талаар судалгаа шинжилгээний ажил хийхээр Зөвлөл төлөвлөж байгаа ба тайлант хугацаанд судалгаа, шинжилгээ хийгдэх ажлын хамрах хүрээг үнэлж байна.</p>	<p>2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх</p>
<p>СТОУС-н “Ангилал” (IFRS Taxonomy)-д бүхэлд нь оруулах шинэчлэлт өөрчлөлт</p>	<p>Уг төслийг 2020 оноос хэрэгжүүлж эхэлсэн ба ирэх онд төсөлд стандартуудыг толилуулсан нэгдсэн цахим платформд нэмэгдсэн шинэчлэлтийг оруулахаар төлөвлөсөн. Мөн олон улсын банк хоорондын суурь хүүг дэлхий дахинд тархсан цар тахалтай холбогдуулан тасралтгүй байдлыг хангах зорилгоор шинэчлэхтэй холбоотой хэрэгжүүлж буй төслийн 2 дах үе шатны ажил үргэлжлэх энэ ажлын хүрээнд СТОУС 9, НББОУС 37 ба СТОУС 7, СТОУС 4, СТОУС 16 гэсэн стандартуудыг дахин үнэлж, хянахаар төлөвлөгдөж байна.</p>	<p>2023 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хэлэлцэх</p>
<p>НББОУС 19 Ажилтны тэтгэмж оруулах өөрчлөлт</p>	<p>Энэхүү баримт бичигт ажилтны тэтгэмжийн тайлагналын ерөнхий толилуулгыг харуулсан шинэ үзүүлэлтийг нэмж оруулахаар төлөвлөсөн ба тухайлбал: зарим төрлийн материаллаг ач холбогдолтой үзүүлэлтийг шинэчлэх юм байна.</p>	<p>2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хэлэлцэх</p>
<p>НББОУС 12 Орлогын албан татвар (2020 онд гарсан нэмэлт өөрчлөлт)</p>	<p>Стандартын 15 ба 24 заалтыг хамрах ба “татвар ногдох түр зөрүү” ба “хасагдах түр зөрүү” зэрэг тодорхойлолтод оруулах өөрчлөлтийг хэлэлцэхээр байна. Эдгээр түр зөрүүний хүлээн зөвшөөрөлтийн хамрах хүрээг илүү нарийвчилсан бөгөөд энэ нь тэнцүү ба нөхөн төлөгддөг түр зөрүү үүсгэдэг гүйлгээг хамрахгүй юм байна.</p>	<p>2022 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр буюу түүнээс хойших хугацаанд хүчин төгөлдөр мөрдөж эхлэх</p>

4.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

Компани нь ирээдүйн үйл ажиллагаатай холбоотой тодорхой тооцоолол ба төсөөлөл ашигладаг. Түүхэн туршлага болон үүссэн нөхцөл байдалд тохиромжтой гэж үзсэн ирээдүйн үйл ажиллагааны тухай таамаглал гэх мэт бусад хүчин зүйлсэд үндэслэн тооцоолол ба шийдлийг тогтмол үнэлдэг. Бодит үр дүн нь тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болно.

4.1 Элэгдүүлэх хөрөнгийн ашиглалтын хугацаа

Компанийн удирдлага нь хүлээгдэж буй хөрөнгийн ашиглалтад суурилан тайлант үе бүрийн эцэст биет бус хөрөнгө болон үл хөдлөх хөрөнгө, тоног төхөөрөмж, компьютер дагалдах хэрэгсэл зэрэг элэгдүүлдэг хөрөнгүүдийн ашиглалтын хугацааг шалгадаг. Гарсан үр дүн нь магадгүй техникийн хуучралтын улмаас тооцоолол ба төсөөллөөс ялгаатай байж болох юм.

4.2 Хойшлогдсон татвар

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр нь санхүүгийн тайланд тусгагдсан хөрөнгө эсвэл өр төлбөрийн дансны дүн болон тэдгээрийн татварын суурийн зөрүүтэй холбоотой ирээдүйд татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох түр зөрүүнээс бий болдог. Мөн түүнчлэн татварын тайлангаар гарсан алдагдал болон ашиглагдаагүй татварын хөнгөлөлттэй холбоотой хойшлогдсон татварын хөрөнгө хүлээн зөвшөөрнө.

4.3 Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт

Компани тайлант үе бүрийн эцэст хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилт хийж үнийн хэлбэлзэл, аливаа үнэ цэнийн бууралт оршин байгаа эсэхийг тодорхойлдог. Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгийн бодит үнэ цэнийн хэмжилтийг зах зээлийн хамгийн боломжит үнэ ханшид суурилан үнэлдэг.

4.4 Нийгмийн хөгжлийн сан

Ажилчдын олон нийтийн арга хэмжээ, баяр ёслолд зориулан нийгмийн хөгжлийн сан байгуулдаг. Сангийн нэмэгдүүлэлт, зарцуулалтыг ажил гүйлгээ гарах бүр удирдлагаас хянаж байдаг. Сан нэмж байгуулах болон зарцуулалтыг зохицуулсан журам заавар эцэслэн батлагдаагүй байна.

4.5 Итгэлцлийн үр шим

Итгэлцлийн үйлчилгээний үр шим нь итгэмжлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс хамааран жилийн 13.2-18.0 хувь боловч итгэмжлэгч нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд итгэлцлийн үр шим жилийн 3,6 хувь болж буурах нөхцөлтэй. Компанийн удирдлагын зүгээс өмнөх жилүүдийн туршлагадаа үндэслэн хугацаанаас өмнө гэрээ цуцлагдах магадлал маш бага гэж үзэж байгаа тул итгэлцлийн үр шимийн өглөгийг жилийн 13.2-18.0 хувиар тооцож аккрузал сууриар бүртгэсэн.

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

4.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ЧУХАЛ ТООЦООЛОЛ БА ШИЙДЭЛ

4.6 Харилцагчдад олгосон зээлийн үнэ цэнийн бууралт

НББОУС 39-ийн дагуу хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын гарз үүссэн гэх бодитой нотолгоо байгаа бол үнэ цэнийн бууралтын гарзыг хүлээн зөвшөөрөхийг шаарддаг байсныг СТОУС 9-өөр санхүүгийн хөрөнгийн нийт амьдралын хугацааны туршид үүсч болзошгүй буюу хүлээгдэж буй гарзын дүнд үндэслэн үнэ цэнийн бууралтыг тооцох шаардлага шинээр тавигдсан. СТОУС 9-ийн дагуу харилцагчдад олгосон бүх зээлийн үлдэгдэлдээ үнэ цэнийн бууралтаас хүлээгдэж буй гарзын дүнг тооцоолж, анх олгосноос хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдсэн зээлүүдийн хувьд тухайн зээлийн нийт үлдсэн хугацааны туршид хүлээж болзошгүй алдагдлаар эрсдлийн санг тооцно. Харин анх олгосноос хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц нэмэгдээгүй зээлүүдийн хувьд ирээдүйн 12 сарын хугацаанд хүлээж болзошгүй алдагдлаар эрсдлийн санг тооцохыг шаардсан.

Компани банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлөөр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу тус хорооноос гаргасан дүрэм журмыг баримтлан ажиллана. Зээлийн эрсдэлийн санг СЗХ-ны дарга, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 05 сарын 13-ны өдрийн 144/125 дугаар тушаалаар батлагдсан “ББСБ-ын активыг ангилал, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-ын дагуу ангилж тооцдог.

Ковид 19 вирус дэлхий нийтийг хамарч цар тахлын хэмжээнд очсоноор улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн төлбөрийн чадвар ихээхэн хэмжээгээр буурсан. Зах зээлд тодорхой бус байдал үүссэн энэ үед зээлдэгчдийн зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2020 оны 3 сарын 18-ны өдрийн 122/58 дугаар хамтарсан тушаалаар, мөн СЗХ-ны даргын 2020 оны 8 сарын 26-ны өдрийн 854 дугаар тогтоолоор дээрх журмын хугацаа хэтрэлтээс хамаарч ангилал шилжүүлэх хоногийг тайлант хугацаанд 2 удаа дараах байдлаар түр өөрчилсөн.

	2020.03.18-ны өдрийн 122/58 тоот хамтарсан тушаал /2020.01.01-2020.07.31-нийг дуустал/	2020.08.26-ны өдрийн 854 тоот тогтоол /2020.12.31-нийг дуустал/
Хэвийн	0-120 хоног	0-90 хоног
Хугацаа хэтэрсэн	121-180 хоног	91-150 хоног
Хэвийн бус	181-270 хоног	151-240 хоног
Эргэлзээтэй	271-360 хоног	241-360 хоног
Муу	361 ба түүнээс дээш хоног	361 ба түүнээс дээш хоног

Зээлийн эрсдэлийн сангийн тооцоолол, баримталсан хувь хэмжээг ерөнхий бодлогын хэсэг, тодруулгын хэсэгт харуулсан.

Мөн ковид 19 цар тахлын нөлөөгөөр үйл ажиллагаа доголдсон, түр саатсан, төлбөрийн чадвар буурсан харилцагчийг дэмжих арга хэмжээний хүрээнд компанийн гүйцэтгэх захирлын 2020 оны 12 сарын 14-ний А-20/60 тоот тушаалаар зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн. Уг тушаалын дагуу хэвийн ангилалд байгаа зээлдэгчдийн өөрсдийн хүсэлтэнд үндэслэн зээлийн төлбөрийг 8 хүртэлх сараар, зээлийн хүүний төлбөрийг 3 хүртэлх сараар сунгахаар шийдвэрлэсэн. Энэ хугацаанд тооцогдох хүүг зогсоогоогүй бөгөөд харилцагч хүсвэл зээл ба хүүний эргэн төлөлтийг дээрх хугацаанд активын чанарын ангиллыг өөрчлөхгүйгээр сунгах боломжтой болсон.

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД

5.1 Санхүүгийн хөрөнгө

Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө

Мөнгөн гүйлгээний тайлангийн зорилгоор, мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд гар дээрх мөнгө, санхүүгийн байгууллагад хадгалагдаж байгаа мөнгө, бусад богино хугацаатай, 3 сар эсвэл түүнээс богино хугацаанд мөнгө болох чадвартай, үнийн өөрчлөлтөнд өртөмтгий бус хөрөнгө оруулалт болон банкны овердрафт багтана.

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Санхүүгийн хөрөнгийг анхны удаа түүний бодит үнэ цэнээр хүлээн зөвшөөрөх ба бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс бусад хөрөнгийн хувьд анхны хүлээн зөвшөөрөлтийн бодит үнэ цэнэд ажил гүйлгээний зардлыг нэмж оруулна. Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ажил гүйлгээний зардлыг тайлант үеийн ашиг алдагдалд тайлагнана.

Ангилал

Санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд хэмжих зорилгоор дараах байдлаар ангилна.

(i) Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгө

Зээл ба авлагууд нь идэвхтэй зах зээлийн жишиг үнэгүй, тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөртэй, үүсмэл биш санхүүгийн хөрөнгүүд юм.

(ii) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө нь арилжааны буюу ашиг олох зорилгоор худалдан аваад богино хугацаанд эргүүлэн худалдах зориулалттай хөрөнгө болон анхнаасаа бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан хөрөнгүүдээс бүрдэнэ.

Идэвхтэй зах зээлийн жишиг үнэ байхгүй, бодит үнэ цэнийг нь хэмжих боломжгүй өмчийн хэрэглүүрт оруулсан хөрөнгө оруулалтыг бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилахгүй.

(iii) Бодит үнэ цэнийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө

Тогтмол эсвэл тодорхойлж болох төлбөр ба тогтсон хугацаа байхгүй, дунд болон урт хугацаанд эзэмшихээр шийдсэн хөрөнгө оруулалт болон өмнө дурдсан ангиллуудын алинд ч багтаагүй санхүүгийн хөрөнгүүдийг энэ ангилалд багтаана.

**“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL**

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.1 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Дараа үеийн хэмжилт

Дараагийн тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгийг үр ашигт хүүний арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийг дараа үеүдэд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн олз, гарзыг дараах байдлаар хүлээн зөвшөөрнө.

- ✓ Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд ашиг, алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлаар
- ✓ Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн үнэт цаас бүхий борлуулах боломжтой санхүүгийн хөрөнгийн хувьд үнэт цаасны хорогдуулсан өртөгт орсон өөрчлөлттэй холбоотой үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдлаар, дансны үнийн бусад өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогоор

Бодит үнэ цэнэ нь ашиг алдагдлаар хэмжигдэх санхүүгийн хөрөнгөөс олсон хүүний орлогыг цэвэр олз, гарзаар тайлагнана. Үр ашигт хүүний аргаар тооцсон хөрөнгө оруулалт болон зээл ба авлагын хүүг ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.

Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн тайланд тайлагнаж байгаа бүх хөрөнгө, өр төлбөрийн бодит үнэ цэнийг тодорхойлох, толилуулахдаа дараах түвшнийг хэрэглэдэг. Үүнд:

- ✓ Түвшин 1-хөрөнгө, өр төлбөрийн хувьд идэвхтэй зах зээл, Тухайлбал: арилжаа солилцооны зах зээл, Дилерийн зах зээл, Брокерийн зах зээл, Оролцогчдын хоорондын зах зээл
- ✓ Түвшин 2-бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх шууд ба шууд бус мэдээлэл: Тухайлбал: Лайбор-ийн ханшид суурилсан, тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп, тодорхой банкны суурь ханшинд суурилсан, тогтмол хүү авч хөвөгч хүү төлөх хүүний түвшний своп,
- ✓ Түвшин 3-бүртгэлд бүртгэгдсэн бодит үнэ цэнэ мэдэгдэхүйц нөлөө үзүүлэх, зах зээл дээр ажиглагддаг мэдээлэл ашиглагдаагүй бусад аргачлалууд,

Үл хүлээн зөвшөөрөлт

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг үл хүлээн зөвшөөрнө.

- ✓ Санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг хүлээж авах эрхийн хугацаа дууссан; эсвэл
- ✓ Компани нь санхүүгийн хөрөнгөөс орж ирэх мөнгөн урсгалыг авах эрхийг шилжүүлсэн бөгөөд (а) санхүүгийн хөрөнгийн эрсдэл, өгөөж бүрэн шилжсэн; эсвэл (б) бүх эрсдэл, өгөөж болон хөрөнгийг шилжүүлээгүй боловч захирах эрхийг нь шилжүүлсэн байх

Бодит үнэ цэнийн хэмжилтийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогын тайланд бүртгэгдэхээр ангилагдсан санхүүгийн хөрөнгийг зарсан бол бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрч байсан хуримтлагдсан бодит үнэ цэнийн тохируулгыг ашиг, алдагдлын тайланд хөрөнгө оруулалтын үнэт цаас борлуулсны олз, гарзаар хүлээн зөвшөөрнө.

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.1 Санхүүгийн хөрөнгө (үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг үнэлнэ. Анх хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон нэг эсвэл хэд хэдэн үйл явдлаас шалтгаалан үнэ цэнийн бууралт бий болсныг харуулах бодитой нотолгоо байгаа бөгөөд уг үйл явдал нь санхүүгийн хөрөнгийн (эсвэл бүлэг санхүүгийн хөрөнгийн) ирээдүйн тооцоолсон мөнгөн урсгалд нөлөөлөхүйц, дүнг тооцоолох боломжтой байгаа үед зөвхөн санхүүгийн хөрөнгийг үнэ цэнэ буурсан гэж үзнэ.

i) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн хөрөнгө

Тайлант үе бүрт хорогдуулсан өртгөөр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн хувьд хөрөнгийн дансны үнэ болон санхүүгийн хөрөнгийн анхны үр ашигт хүүг ашиглан дискаунтчилсан ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн зөрүүгээр үнэ цэнийн бууралтын алдагдлыг тооцно. Хөрөнгийн дансны үнийг бууруулж, үнэ цэнийн бууралтын алдагдлыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө. Дараагийн хугацаанд үнэ цэнийн бууралтыг хүлээн зөвшөөрсний дараа тохиолдсон үйл явдал (зээлийн чанар сайжирсан гм)-тай холбоотойгоор үнэ цэнийн бууралтын алдагдал буурсан бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн бууралтын буцаалтыг ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

(ii) Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгө

Бодит үнэ цэнээр хэмжигдэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнэ буурсныг илтгэх бодитой нотолгоо байгаа бол худалдан авсан өртөг болон одоогийн бодит үнэ цэнэ (өмнө нь хүлээн зөвшөөрсөн санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтыг хассаны дараах) хоорондын зөрүүнээс хуримтлагдсан алдагдлаар өмчийг бууруулж, ашиг алдагдлаар хүлээн зөвшөөрнө.

Ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрсөн байсан өмчийн хэрэглүүрт тооцсон үнэ цэнийн бууралтын алдагдлыг дараагийн хугацааны туршид ашиг алдагдал руу буцаахгүй.

Бодит үнэ цэнийн хэмжилтийн өөрчлөлт нь бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэгдэх санхүүгийн хөрөнгө гэж ангилсан санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнэ өсөлт эсвэл бууралт дараагийн үеүдэд өссөн эсвэл буурсан бол уг өсөлт, бууралтыг өмнөх хугацаанд хүлээн зөвшөөрсөн үнэ цэнийн өсөлт, бууралтын нэгэн адил бусад дэлгэрэнгүй орлогоор бүртгэнэ.

5.2 Санхүүгийн өр төлбөр

Компани өр төлбөрийн зорилгоос хамаарч санхүүгийн өр төлбөрөө дараах хоёр ангиллын аль нэгээр нь ангилдаг.

- ✓ Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр
- ✓ Бусад санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөр

Бодит үнэ цэнэ нь ашиг, алдагдлаар хэмжигдэх санхүүгийн өр төлбөрт зөвхөн алдагдалтай санхүүгийн үүсмэл хэрэглүүр багтана. Энэхүү ангилалд багтсан санхүүгийн өр төлбөрийг Санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь тусгаж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг Орлого үр дүнгийн тайланд тусгана. Ашиг олох зорилгоор бус харин эрсдэлээс хамгаалах зорилгоор үүсмэл хэрэглүүр эзэмшиж гаргадаг. Эдгээр үүсмэл санхүүгийн хэрэглүүрээс бусад тохиолдолд арилжаалагдах зорилготой эсвэл бодит үнэ цэнийг нь ашиг, алдагдлаар нь хэмжих зорилготой санхүүгийн өр төлбөр байхгүй болно.

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.2 Санхүүгийн өр төлбөр (үргэлжлэл)

Бусад санхүүгийн өр төлбөр

Бусад санхүүгийн өр төлбөрт дараах зүйлс багтана.

- Банкны зээл болон бусад хүү тооцогдох санхүүгийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрөхдөө тухайн хэрэглүүрийг гаргахтай шууд холбоотой зардлыг бодит үнэ цэнээс хассан дүнгээр бүртгэнэ. Ийм төрлийн хүүтэй өр төлбөрийг дараа үеүдэд бүртгэхдээ үр ашигт хүүний түвшинг ашиглан хорогдуулсан өртгөөр хэмждэг. Санхүүгийн өр төлбөрийн хүүний зардалд анхны ажил гүйлгээний зардал, эргэлтээс гаргах өдөр төлөгдөх аливаа нэмүү өртөг болон төлөгдөөгүй өрийн хүү, эсвэл купон багтана.
- Анх бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрсөн дансны өглөг ба бусад богино хугацаат мөнгөөрх өр төлбөрийг дараа үеүдэд үр ашигт хүүний түвшинг хэрэглэн хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

Компани санхүүгийн өр төлбөрийг тус өр төлбөртэй холбоотой үүрэг хариуцлага цуцлагдсан, чөлөөлөгдсөн болон хугацаа нь дуусгавар болсон үед үл хүлээн зөвшөөрнө.

5.3 Эрсдэлийн сан

Санхүүгийн Зохицуулах Хорооны дарга болон Сангийн сайдын 2015 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 144/125 тоот тушаалаар батлагдсан “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах журам”-ын дагуу активыг эргэн төлөлтийн хугацаа хэтрэлт болон чанараар хэмжин доорх байдлаар ангилж үлдэгдлээс нь эрсдэлийн сан байгуулна.

	Эрсдэлийн сангийн хувь
Хэвийн	Сан байгуулахгүй
Хугацаа хэтэрсэн	5%
Хэвийн бус	25%
Эргэлзээтэй	50%
Муу	100%

5.4 Үндсэн хөрөнгө

Анхны хүлээн зөвшөөрөлт ба хэмжилт

Бүх үндсэн хөрөнгө анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл ба хуримтлагдсан үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгагдана. Анхны өртөгт хөрөнгийг худалдан авахтай шууд холбоотой зардлууд багтана. Мөн өртөгт гадаад валютаар худалдан авсан үндсэн хөрөнгийн мөнгөн урсгалын хэйджийн олз/гарзын өмчийн дүнгээс шилжүүлсэн хэсэг орно.

Дараагийн үеийн зардлуудыг хөрөнгийн дансны үнэд багтаах эсвэл тухайн хөрөнгөтэй холбоотой эдийн засгийн өгөөжийг хүртэх боломжтой, өртгийг нь найдвартай тооцох боломжтой бол тусдаа хөрөнгөөр бүртгэнэ. Тусдаа хөрөнгөөр бүртгэгдсэн хэсгийг орлуулсан үед дансны үнээр нь үл хүлээн зөвшөөрнө. Бусад засвар үйлчилгээтэй холбоотой гарсан зардлыг гарсан үед нь тайлант хугацааны ашиг алдагдлын тайланд тусгана.

Данснаас хассанаас үүссэн олз, гарзыг хөрөнгийн дансны үнийг хүлээн авсан төлбөртэй нь харьцуулан тодорхойлох ба тэдгээрийг ашиг алдагдлын тайланд тусгана.

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.4 Үндсэн хөрөнгө (үргэлжлэл)

Элэгдэл

Үндсэн хөрөнгийн элэгдлийг шулуун шугамын аргаар байгуулдаг ба ашиглалтын хугацаа дараах байдалтай байна.

Үндсэн хөрөнгийн Төрөл	Элэгдэл байгуулах жил
Барилга байгууламж	25
Тээврийн хэрэгсэл	10
Тавилга эд хогшил	5-10
Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	2

ААНОАТ-ын тухай хууль шинэчлэгдэж, 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан барилга байгууламжийн ашиглалтын хугацааг 25 жил, компьютер, түүний дагалдах хэрэгслийн ашиглалтын хугацааг 2 жил байхаар шинэчлэн тогтоосон.

5.5 Санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралт

Тайлант хугацаа бүрийн эцэст санхүүгийн бус хөрөнгүүдийн дансны үнийг нягтлан үзэж үнэ цэнэ буурсан байх шинж байгаа эсэхийг тодорхойлно. Хэрэв үнэ цэнэ буурсан шинж илэрвэл хөрөнгийн нөхөгдөх дүнг тооцно.

Үнэ цэнийн бууралтыг шалгахдаа хөрөнгүүдийг бүлэглэх ба ингэхдээ бусад хөрөнгүүд болон мөнгө үүсгэгч нэгжүүдээс орох мөнгөн урсгалаас ангид, дангаараа цаашид үргэлжлүүлэн ашигласнаар мөнгөн орох урсгал бий болгох хөрөнгүүдийн хамгийн жижиг бүлэг байхаар бүлэглэнэ.

Тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн нөхөгдөх дүнг ашиглалтын үнэ цэнэ болон бодит үнэ цэнээс борлуулахтай холбоотой зардлыг хассан цэвэр дүнгийн аль ихээр тооцно. Ашиглалтын үнэ цэнэ нь татварын өмнөх дискаунтын түвшин (мөнгөний үнэ цэнийн одоогийн зах зээлийн үнэлгээ болон тухайн хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн эрсдэл зэргийг агуулсан)-г ашиглан ирээдүйн тооцсон мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнээр тооцогдоно.

Хөрөнгө эсвэл мөнгө үүсгэгч нэгжийн дансны үнэ нь нөхөгдөх дүнгээс их бол үнэ цэнийн бууралтын алдагдлыг хүлээн зөвшөөрнө.

5.6 Өөрийн хөрөнгө

Хувьцаат капитал

Энгийн хувьцааг өмчөөр ангилж тайлагнасан. Буцаан дуудах давуу эрхийн хувьцааг өр төлбөрөөр ангилж тайлагнана. Шинээр хувьцаа гаргахтай холбоотой шууд хуваарилагдах өсөн нэмэгдэх зардлыг аливаа татварын нөлөөг хассан дүнгээр нь өмчийн хэсэгт тайлагнана.

Хуримтлагдсан ашиг, алдагдал

Компани үүсгэн байгуулснаас хойш хугацаанд компанид хуримтлагдсан ашиг, алдагдлын нийлбэрийг хуримтлагдсан ашиг дансанд бүртгэх ба оруулсан хөрөнгийг ашиглан бий болгосон нэмэлт эх үүсвэрийн хэмжээг харуулна.

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.7 Хүүний орлого, зардал

Хүүний орлого, зардлыг үр ашигт хүүний түвшинг ашиглан үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгүүдээс бусад санхүүгийн хэрэглүүрүүдийн хувьд ашиг, алдагдал болон дэлгэрэнгүй орлогын тайланд аккруэл сууриар бүртгэдэг. Үр ашигт хүүний арга нь санхүүгийн хөрөнгө ба санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг тооцож хүүний орлого зардлыг холбогдох хугацаанд нь хуваарилдаг арга юм. Үнэ цэнэ буурсан санхүүгийн хөрөнгийн хувьд компани санхүүгийн хөрөнгийн цэвэр хорогдуулсан өртгийг илэрхийлэх үр ашигт хүүний түвшинг ашиглан хүүний орлогыг тооцдог. Хэрэв санхүүгийн хөрөнгийн чанар сайжирч, үнэ цэнийн бууралт цаашид үргэлжлэхээргүй бол нийт сууриарх хүүний орлогын тооцооллыг буцаан хэрэглэдэг.

5.8 Шимтгэл, хураамжийн орлого

Хураамж шимтгэлийн орлого нь харилцагчдад санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр авч байгаа төлбөр юм. Хураамж шимтгэлийн орлогыг тухайн зээлийг олгосон үед орлогоор хүлээн зөвшөөрдөг.

5.9 Засгийн газрын буцалтгүй тусламж

Засгийн газрын буцалтгүй тусламж гэдэг нь аж ахуйн нэгжийн үйл ажиллагаатай холбоотой өнгөрсөн болон ирээдүйн хугацаанд дагаж мөрдөх тодорхой нөхцөлтэйгөөр аж ахуйн нэгжид нөөц хэлбэрээр шилжүүлсэн Засгийн газрын тусламж юм. Засгийн газрын буцалтгүй тусламжийг системтэй сууриар, холбоотой зардлыг харгалзан нөхөх байдлаар уг зардлыг хэрэгжих тайлангийн үеүдэд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Засгийн газрын буцалтгүй тусламжийг бүртгэх нягтлан бодох бүртгэлийн хоёр нийтлэг арга байна. Капиталын арга нь буцалтгүй тусламжийг ашиг, алдагддаас гадуур хүлээн зөвшөөрч бүртгэдэг бол орлогын арга нь буцалтгүй тусламжийг нэг ба түүнээс дээш тайлангийн үеүдэд ашиг, алдагдлаар хүлээн зөвшөөрч бүртгэдэг.

5.10 Үйл ажиллагааны зардал

Тайлант хугацаанд хувь нийлүүлэгчид хуваарилснаас бусад шалтгааны улмаас мөнгөний гадагш урсгал хэлбэрээр хөрөнгийг бууруулж, өр төлбөр ихэсгэдэг эдийн засгийн өгөөжийн бууралт гарах үед зардлыг хүлээн зөвшөөрдөг. Зардлыг тухайн гарсан жилд нь ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

5.11 Гадаад валютаарх ажил гүйлгээ ба үлдэгдэл

Гадаад валютаар илэрхийлэгдсэн мөнгөн хөрөнгө болон өр төлбөрийг тайлагналын өдрийн хаалтын ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба бодит үнэ цэнээрээ хэмжигдсэн мөнгөн бус хөрөнгө, өр төлбөрийг уг бодит үнэ цэнийг тодорхойлсон өдрийн албан ханшаар бүртгэлийн валют руу хөрвүүлэн илэрхийлдэг. Гадаад валютаар илэрхийлэгдсэн ба түүхэн өртгөөр хэмжигдсэн мөнгөн бус зүйлсийг тухайн ажил гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлдэг. Гадаад валютын ханшийн зөрүүг ерөнхийдөө ашиг эсвэл алдагдлаар хүлээн зөвшөөрдөг.

Зээлтэй холбоотой ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг алдагдлын тайланд санхүүгийн зардал багтаан тайлагнана. Бусад ханшийн зөрүүний олз, гарзыг ашиг алдагдлын тайланд бусад орлого эсвэл бусад зардлын цэвэр дүнгээр тайлагнана.

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.12 Түрээс

Түрээсийн гэрээний хүрээнд эзэмшиж буй ашиглах эрх бүхий хөрөнгө болон түүнтэй холбоотой түрээсийн өр төлбөрийг түрээсийн хугацааны эхэнд шаардах эрх бүхий хөрөнгө болон богино хугацаат эсвэл урт хугацаат өр төлбөрөөр хүлээн зөвшөөрч бүртгэх ба богино хугацаанд буюу 12 сарын хугацаатай эсвэл бага үнэ цэнэтэй түрээсээс бусад түрээсийн хувьд уг зарчмаас чөлөөлөгдөхгүй. Түрээсийн гэрээний дагуу олж авсан шаардах эрх бүхий хөрөнгийг тус хөрөнгөөс хүртэж буй эдийн засгийн өгөөжтэй нь уялдуулан түрээсийн хугацаанд системтэйгээр ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрдөг.

Богино хугацаат буюу 12 сарын хугацаатай эсвэл бага үнэ цэнэ бүхий түрээсийн хувьд түрээсийн үүрэг хариуцлагыг санхүүгийн зардлыг хассан цэвэр дүнгээр нь богино хугацаат өр төлбөрийн хэсэгт харуулдаг. Түрээсийн төлбөрийг өр төлбөр ба санхүүгийн зардал гэсэн 2 хэсэгт ангилна. Санхүүгийн зардлыг түрээсийн хугацааны туршид ашиг алдагдлын тайланд тусгах ба тайлант хугацаа бүрийн хувьд өр төлбөрийн үлдэгдэлд тооцогдох тогтмол хугацааны хүүг тооцоолох шаардлагатай. Урт хугацаат түрээсийн гэрээний дагуу олж авсан үндсэн хөрөнгийг хөрөнгийн ашиглалтын хугацаанд эсвэл түрээсийн хугацааны эцэст эзэмших эсэхийг тодорхойлох боломжгүй үед хөрөнгийн ашиглалтын хугацаа болон түрээсийн хугацааны аль богино хугацаанд элэгдүүлнэ.

5.13 Ажилчдын тэтгэмж

Ажилтан аж ахуйн нэгжид үзүүлсэн үйлчилгээний хариуд тайлант үеийн эцсээс хойших арван хоёр сарын хугацаанд багтаан авахаар тохиролцсон ажилтны тэтгэмж болох цалин, хөлс болон мөнгөн бус тэтгэмжүүдийг тайлант хугацааны эцсийг хүртэлх хугацаанд үзүүлсэн үйлчилгээнд суурилан хүлээн зөвшөөрөх ба төлбөрийг барагдуулах үед төлөгдөх дүнгээр хэмжинэ.

Ажилтны үйлчилгээ үзүүлсэн хугацаанаас хойш арван хоёр сараас илүү хугацаанд төлөгдөх бусад урт хугацааны тэтгэмжинд удаан жил ажилласны тэтгэмж болон жилийн амралт зэрэг багтах ба төлөвлөсөн нэгжийн кредит аргыг ашиглан тайлант жилийн эцэс хүртэл үзүүлсэн үйлчилгээтэй нь уялдуулан ирээдүйн тооцоолсон төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр хэмжинэ.

Стандартаар заасан бусад хэлбэрүүд болох ажил эрхлэлтийн дараах тэтгэмж болон ажлаас халагдсаны тэтгэмж нь МУ-ын холбогдох хуулийн дагуу төрөөс төлөгддөг бөгөөд байгууллагын хувьд төлбөр төлөх үүрэг хүлээдэггүй.

5.14 Болзошгүй өр төлбөр

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хуулийн дагуу эсвэл үүсмэл үүрэг хариуцлага хүлээсэн, хүлээсэн үүрэг хариуцлагын төлбөрийг барагдуулахад эдийн засгийн өгөөж бүхий нөөцийн урсгал гадагшлах магадлалтай болсон, мөн үүрэг хариуцлагын дүнг найдвартай тооцоолох боломжтой үед хуулийн зарга маргааны нэхэмжлэл, бүтээгдэхүүний баталгаа, гэрээний үүрэг хариуцлага зэргийг хүлээн зөвшөөрнө. Ирээдүйн үйл ажиллагааны алдагдалд зориулан болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөхгүй.

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.15 Татварын бүртгэл

Орлогын албан татвар

Орлогын албан татварыг тайлант үеийн эцэст хүчин төгөлдөр хэрэгжиж байсан эсвэл ирээдүйд хэрэгжих хууль тогтоомжийн дагуу санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрнө. Орлогын албан татварын зардал нь тухайн жилийн татварын зардал болон хойшлогдсон татвараас бүрдэх бөгөөд уг зардлуудтай холбоотой ажил гүйлгээ нь тухайн жил эсвэл өөр тайлант хугацаанд бусад дэлгэрэнгүй орлогод эсвэл өмчид шууд бүртгэснээс бусад тохиолдолд тухайн жилийн орлого, зарлагад хүлээн зөвшөөрөгдөнө.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөр

Хойшлогдсон татвар нь санхүүгийн тайлагналын зорилгоор бүртгэсэн хөрөнгө болон өр төлбөрийн дансны үнэ ба татварын тайлагналын зорилгоор бүртгэсэн үнийн зөрүүнээс үүссэн түр зөрүү юм. Хойшлогдсон татварыг тайлагнах өдрөөрх болон цаашид хэрэгжих хуульд үндэслэн буцаалт хийгдэх түр зөрүүнд хэрэгжихээр хүлээгдэж байгаа татварын хувиар тооцдог.

Хойшлогдсон татварын хөрөнгө, өр төлбөрийг татвар ногдуулах нэг аж ахуйн нэгжид хамаарах татварын байгууллагаас тогтоосон тайлант үеийн татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөрийн эсрэг хуулийн эрх үүргийн дагуу хооронд нь хааж болох бөгөөд гэхдээ эдгээр татвар ногдуулах хөрөнгө, өр төлбөр нь цэвэр дүнд суурилсан байх хэрэгтэй. Ирээдүйн татвар ногдуулах ашиг нь татварын түр зөрүүг нөхөхүйц байх тохиолдолд хойшлогдсон татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Хойшлогдсон татварын хөрөнгийг тайлант үе бүрд хянаж холбогдох татварын өгөөжийг хэрэгжүүлэх буюу бууруулдаг.

НББОУС 12 болон ААНОАТ-ын тухай хууль тогтоомжийн зөрүүтэй байдал

Орлогын албан татварын байнгын болон түр зөрүүг хэрхэн тодорхойлж, тайлагнах талаар НББОУС 12 Орлогын албан татвар болон Сангийн Сайдын 121-р тогтоолоор батлагдсан “Санхүүгийн тайлангийн болон орлогын албан татварын тайлангийн үзүүлэлт хоорондын зөрүүг зохицуулах журам”-ын зарим ойлголтууд хоорондоо зөрүүтэй байдаг.

Компани нь МУ-ын хууль тогтоомжоор шаардсаны дагуух татвар, шимтгэлийн төлөлт, ногдуулалт, тайлагналтай холбоотой бүх тооцоолол, бүртгэлийг өөрсдөө дотооддоо хийж гүйцэтгэдэг.

**“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL**

5.НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН ГОЛ БОДЛОГУУД (үргэлжлэл)

5.16 Холбоотой талууд

Холбоотой тал гэдэг нь санхүүгийн тайлан бэлтгэж байгаа байгууллагатай холбоотой хүн эсвэл байгууллага юм. Тухайн хүн эсвэл тэр хүний гэр бүлийн ойрын гишүүн нь тайлагнагч байгууллагатай холбоотой бөгөөд уг хүн нь:

- a) Тайлагнагч байгууллагад хяналттай эсвэл хамтарсан хяналттай,
- b) Тайлагнагч байгууллагад үлэмж хэмжээний нөлөөтэй,
- c) Тайлагнагч байгууллага, тайлагнагч байгууллагын толгой компанийн гол удирдлагын багийн гишүүн байх,

Хэрэв дараах нөхцөлийн аль нэг оршин байгаа бол байгууллага нь тайлагнагч байгууллагатай холбоотой гэж үзнэ. Үүнд:

- a) Байгууллага ба тайлагнагч байгууллага нь нэг ижил байгууллагын (энэ нь толгой, охин болон дэд охин компани нь бусадтай холбоотой байх) гишүүд байх,
- b) Нэг байгууллага нөгөө байгууллагын хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх (эсвэл нөгөө байгууллагын гишүүнчлэлтэй нэг гишүүний хараат компани эсвэл хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын нэг тал нь байх),
- c) Хоёр компани нь нэг ижил гуравдагч талын хамтарсан үйлдвэр/хөрөнгө оруулалтын талууд байх,
- d) Нэг байгууллага нь гуравдагч байгууллагын хамтарсан үйлдвэр/хамтарсан хөрөнгө оруулалтын нэг хэсэг болох ба нөгөө байгууллага нь гуравдагч байгууллагын хараат компани болох,
- e) Байгууллага нь тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагатай холбоотой байгууллагын аль алины ажилчдын тэтгэмжийн “ажил эрхлэлтийн дараах тогтоосон тэтгэмжийн төлөвлөгөө”-нд хамаарах. Хэрэв тайлагнагч байгууллага нь өөрөө энэ төлөвлөгөөний нэг хэсэг бол спонсор ажил олгогчид нь тайлагнагч байгууллагатай мөн холбоотой талууд болно.
- f) Байгууллагад (а)-д тодорхойлогдсон хүн хяналт тавьдаг эсвэл хамтарсан хяналт тавьдаг байх,
- g) (а), (а)-д тодорхойлогдсон хүн нь байгууллагад үлэмж нөлөө үзүүлдэг эсвэл байгууллагын (эсвэл байгууллагын толгой компанийн) гол удирдлагын багийн гишүүн байх,
- h) Байгууллага, эсвэл нэг хэсэг нь болж байгаа өөр бусад гишүүн, тайлагнагч байгууллага эсвэл тайлагнагч байгууллагын толгой компани руу гол удирдлагын ажилтнаар хангах,

**“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL**

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6. САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД****2020 оны жилийн эцсийн байдлаар дараах санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрүүд байна.**

	Тодруулга	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн хөрөнгө			
Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгө	6.1.	9,396,151.2	1,210,084.9
Харилцагчдад олгосон зээл /цэвэр/	6.2.	21,119,560.5	28,722,977.8
Хуримтлуулж тооцсон хүүний авлага	6.2.	1,278,642.3	387,241.3
Санхүүгийн хөрөнгийн дүн		31,794,354.0	30,320,304.0
Хорогдуулсан өртгөөр хэмжих санхүүгийн өр төлбөр			
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээл	6.3.		4,610,765.5
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	6.4.	8,086,856.2	6,509,370.0
Хуримтлуулж тооцсон хүүний өглөг	6.5.	476,377.2	359,058.6
Санхүүгийн өр төлбөрийн дүн		8,563,233.4	11,479,194.1

6.1. Тодруулга-МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ХӨРӨНГӨ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Бэлэн мөнгө-Төгрөг	116.9	318.9
Банкны харилцах дансанд байршуулсан мөнгө -Төгрөг	659,554.5	1,209,099.5
Банкны харилцах дансанд байршуулсан мөнгө -Ам доллар	416.7	666.5
Банкны харилцах дансанд байршуулсан мөнгө -Евро	152.4	
Банкны хадгаламжийн дансанд байршуулсан мөнгө-Төгрөг	8,735,910.6	
Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	9,396,151.2	1,210,084.9

Мөнгөн хөрөнгийн дүнд барьцаалуулсан эсвэл захиран зарцуулалтыг нь хязгаарласан мөнгөн хөрөнгө байхгүй. Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн дансны үнэ нь бодит үнэ цэнэтэйгээ материаллаг зөрүүгүй. Банкин дахь мөнгөн хадгаламжийн хугацаа, хүүний талаарх мэдээллийг дараах хүснэгт харуулна.

	Хүүний түвшин /жилээр/	Нээсэн огноо	Дуусах огноо	2020.12.31 мянган төгрөг
Хаан банк-1	7.6%	2020.11.06	2021.01.04	4,140,000.0
Хаан банк-2	7.0%	2020.10.07	2021.01.06	255,910.6
Голомт банк	7.2%	2020.10.05	2021.01.06	1,400,000.0
Кредит банк	14.0%	2020.12.14	2021.02.14	1,440,000.0
Тээвэр хөгжлийн банк	14.0%	2020.12.15	2021.03.15	1,500,000.0
Дүн				8,735,910.6

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан
Санхүүгийн тайлангийн тодруулга

6.2. Тодруулга-ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ

Зээлийн ангилал	2020.12.31		2019.12.31	
	Зээл	Эрсдэлийн сан	Зээл	Эрсдэлийн сан
Хэвийн	15,068,440.7	15,068,440.7	24,832,393.3	24,832,393.3
Анхаарал хандуулах	5,439,832.9	271,991.6	3,747,197.8	187,359.9
Хэвийн бус	454,176.8	113,544.2	357,228.9	89,307.2
Эргэлзээтэй	1,085,291.8	542,645.9	125,649.8	62,824.9
Муу	689,796.5	689,796.5	699,141.8	699,141.8
Дүн	22,737,538.7	1,617,978.2	29,761,611.6	1,038,633.8
		21,119,560.5		28,722,977.8

Зээлийн дүнд холбоотой талуудад олгосон 2,264,948.4 мянган төгрөгийн зээл багтсан. Холбоотой талуудад олгосон зээлийн дэлгэрэнгүйг тодруулга 6.19-д харуулсан. Дээрх зээлийн үлдэгдэлд компани өөрийн болон гуравдагч талын нэрийн өмнөөс ямар нэг үүргийн гүйцэтгэлд барьцаалуулсан, баглан даалт гаргасан зээл байхгүй.

Компани банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн дагуу тус хорооноос гаргасан дүрэм журмыг баримтлан ажиллана. Зээлийн эрсдэлийн санг СЗХ-ны дарга, Сангийн сайдын хамтарсан 2015 оны 5 сарын 13-ны өдрийн 144/125 дугаар тушаалаар батлагдсан “ББСБ-ын активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж зарцуулах журам”-ын дагуу ангилж тооцдог.

Ковид 19 вирус дэлхий нийтийг хамарч цар тахлын хэмжээнд очоноор улс орны эдийн засагт сөргөөр нөлөөлж аж ахуйн нэгж байгууллага, иргэдийн төлбөрийн чадвар ихээхэн хэмжээгээр буурсан. Зах зээлд тодорхой бус байдал үүссэн энэ үед зээлдэгчдийн зээлийн төлбөрийн дарамтыг бууруулах зорилгоор СЗХ-ны дарга, Сангийн сайдын 2020 оны 3 сарын 18-ны өдрийн 122/58 дугаар хамтарсан тушаалаар, мөн СЗХ-ны даргын 2020 оны 8 сарын 26-ны өдрийн 854 дугаар тогтоолоор дээрх журмын хугацаа хэтрэлгээс хамаарч ангилал шилжүүлэх хоногийг тайлант хугацаанд 2 удаа дараах байдлаар түр өөрчилсөн.

	2020.03.18-ны өдрийн 122/58 тоот хамтарсан тушаал	2020.08.26-ны өдрийн 854 тоот тогтоол
	/2020.01.01-2020.07.31-нийг дуустал/	/2020.12.31-нийг дуустал/
Хэвийн	0-120 хоног	0-90 хоног
Хугацаа хэтэрсэн	121-180 хоног	91-150 хоног
Хэвийн бус	181-270 хоног	151-240 хоног
Эргэлзээтэй	271-360 хоног	241-360 хоног
Муу	361 ба түүнээс дээш хоног	361 ба түүнээс дээш хоног

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан
Санхүүгийн тайлангийн тодруулга

6.2. Тодруулга-ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (үргэлжлэл)

Зээлийн хүүний түвшин нь зээлийн бүтээгдэхүүний төрөл болон нийслэл, орон нутгаас хамааран харилцан адилгүй бөгөөд 2020 оны жилийн эцсийн байдлаар давхардсан тоогоор 1,978 (2019 онд 1,914) зээлдэгчид сарын 1,0%-иас 5.0%-ийн хүүтэйгээр олгосон 22,737,538.7 мянган төгрөгийн зээлийн үлдэгдэлтэй байна. Зээлийн үлдэгдлийг бүтээгдэхүүний төрөл, хүүний түвшнээр нь доорх хүснэгтэн мэдээлэл харуулна.

	2020.12.31		2019.12.31	
	мянган төгрөг	Зээлийн хүү сараар	мянган төгрөг	Зээлийн хүү сараар
Эргэлтийн хөрөнгө барьцаалсан зээл	4,234,998.0	2.2%-2.9%	10,634,998.2	2.2%
БСХС-ийн теслийн зээл	17,177.7	2.0%	132,841.4	2.0%
Итгэлцэл барьцаалсан зээл	42,499.3	2.2%-2.4%	74,000.0	2.4%-2.5%
Монгол шошго зорилгот зээл			421.6	1.0%
Цалингийн зээл	435,718.6	1.0%-5.0%	463,410.4	1.0%-1.9%
Автолизингийн зээл	5,064,417.6	2.5%-3.5%	6,048,791.9	2.5%-3.3%
Автомашин унаж явах нөхцөлтэй зээл	1,873,177.9	2.2%-3.7%	1,502,273.7	3.0%-3.7%
Автомашин хадгалах нөхцөлтэй зээл	248,197.5	3.0%	540,240.9	3.0%
Орон сууц барьцаалсан шуурхай зээл	478,897.0	2.99%-3.7%	661,489.1	3.3%-3.7%
Орон сууц, объект барьцаалсан судалгаагай зээл	8,184,581.8	2.5%-3.5%	8,154,117.3	2.8%-3.5%
Сургалтын зээл			648.1	3.9%
Хашаа байшин барьцаалсан зээл	918,962.8	2.7%-3.5%	929,305.7	2.8%-3.5%
Хялбар зээл	113,964.7	3.0%-5%	172,807.1	3.5%-5.0%
Шугамын зээл	649,952.6	3.0%	399,995.1	3.0%-3.2%
Кредит картын зээл	372,655.6	2.0%-4.5%	14,067.1	2.0%-4.5%
Автомашинны гаалийн бичиг барьцаалсан зээл	99,908.4	2.7%	23,995.6	3.5%
Газар барьцаалсан зээл	2,429.4	3.7%	8,208.3	3.7%
Нийт зээлийн дүн	22,737,538.7		29,761,611.6	
	(1,617,978.2)		(1,038,633.8)	
Цэвэр зээлийн дүн	21,119,560.5		28,722,977.8	

Зээлийн эрсдэлийн сан

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.2. Тодруулга-ХАРИЛЦАГЧДАД ОЛГОСОН ЗЭЭЛ (үргэлжлэл)****Зээлийн эрсдэлийн сангийн хөдөлгөөн**

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Сангийн эхний үлдэгдэл	1,038,633.8	238,750.3
Тайлант хугацаанд нэмж байгуулсан	646,870.6	903,839.8
Тайлант хугацаанд буурсан	(67,526.2)	(103,956.3)
Сангаас хаасан зээл		-
Бусад тохируулга		
Сангийн эцсийн үлдэгдэл	1,617,978.2	1,038,633.8

Хуримтлуулж тооцсон хүүний авлага

Хүүний авлага нь харилцагч нарт олгосон зээлийн хүүний авлага болон банкин дахь богино хугацаат хадгаламжийн хүүний авлагын дүнг илэрхийлнэ.

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Хэвийн хүүний авлага	923,613.8	342,940.0
Хугацаа хэтэрсэн хүүний авлага	296,203.1	42,026.7
Торгуулийн хүүний авлага	9,942.8	2,274.6
Хадгаламжийн хүүний авлага	48,882.7	
Дүн	1,278,642.3	387,241.3

Ковид 19 цар тахлын нөлөөгөөр үйл ажиллагаа доголдсон, түр саатсан, төлбөрийн чадвар буурсан харилцагчийг дэмжих арга хэмжээний хүрээнд компанийн гүйцэтгэх захирлын 2020 оны 12 сарын 14-ний А-20/60 тоот тушаалаар зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулахыг зөвшөөрсөн. Уг тушаалын дагуу хэвийн ангилалд байгаа зээлдэгчдийн өөрсдийн хүсэлтэнд үндэслэн зээлийн төлбөрийг 8 хүртэлх сараар, зээлийн хүүний төлбөрийг 3 хүртэлх сараар сунгахаар шийдвэрлэсэн. Энэ хугацаанд тооцогдох хүүг зогсоогоогүй бөгөөд харилцагч хүсвэл зээл ба хүүний эргэн төлөлтийг дээрх хугацаанд активын чанарын ангиллыг өөрчлөхгүйгээр сунгах боломжтой болсон.

6.3. Тодруулга-БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Голомт банкны зээл-1	-	620,000.0
Голомт банкны зээл-2	-	3,600,000.0
Капитрон банкны овердрафт	-	180,765.5
Бичил санхүүгийн хөгжлийн сангийн зээл	-	210,000.0
Дүн	-	4,610,765.5

Үүнээс: Урт хугацаанд төлөгдөх

Голомт банк зээл-1	-	380,000.0
Бичил санхүүгийн хөгжлийн сангийн зээл	-	90,000.0

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC

CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

6.3. Тодруулга- БАНК САНХҮҮГИЙН БАЙГУУЛЛАГААС АВСАН ЗЭЭЛ (үргэлжлэл)

Голомт банкны зээл-1

Голомт банк болон Очир Ундраа ОМЗ ББСБ-ын хооронд 2018 оны 05 сарын 16-ны өдөр **ЗГ8145100605** тоот зээлийн гэрээ байгуулж тус банкнаас жилийн 18.0 хувийн хүүтэй, 50 сарын хугацаатайгаар 1,000,000.0 мянган төгрөг зээлсэн. Уг зээлийн үлдэгдлийг тайлант хугацаанд бүрэн төлж барагдуулсан.

Голомт банкны зээл-2

Хувьцаа эзэмшигчийн 19/04 тоот шийдвэрийн дагуу компани нь 2019 оны 05 сарын 27-ны өдөр Голомт банктай **ЗГС190005086-3/LNFL** тоот зээлийн шугамын гэрээ 12 сарын хугацаатайгаар байгуулсан. Гэрээний дагуу олгох зээлийн хэмжээ 4,000,000.0 мянган төгрөг бөгөөд зээлийн хүү жилийн 19.0 хувь, зээлийн эх үүсвэрийг нөөцлөн баталгаажуулсны шимтгэлд сар бүр зээлийн эрхийн ашиглаагүй хэсгийн дүнгээс жилийн 4.0 хувиар тооцох нөхцөлтэй. Уг зээлийн үлдэгдлийг тайлант хугацаанд бүрэн төлж барагдуулсан.

Бичил санхүүгийн хөгжлийн сангийн зээл:

2018 оны 8 сарын 2-ны өдөр тус сантай жилийн 6.5 хувийн хүүтэй, 36 сарын хугацаатай, зээлийн зарцуулагдаагүй үлдэгдэлд сар бүр 0.541 хувийн шимтгэл тооцох, Орхон аймаг, Баянгол дүүрэг, Баянзүрх дүүрэгт тус бүр 100,000.0 мянган төгрөгийг зарцуулах нөхцөлтэй 300,000.0 мянган төгрөгийн зээл авах эрхийг баталгаажуулж 38/06 тоот дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Энэхүү гэрээний хүрээнд авсан зээл 210,000.0 мянган төгрөгийн үлдэгдэлтэй байсныг тайлант хугацаанд бүрэн төлж барагдуулсан.

Капитрон банкны овердрафт зээл:

Хувьцаа эзэмшигчийн 19/06 тоот шийдвэрийн дагуу компани 2019 оны 8 сарын 21-нд Капитрон банктай №3096-2019/107 тоот овердрафт зээлийн эрх нээх гэрээ байгуулсан. Овердрафт зээлийн хэмжээ 300,000.0 мянган төгрөг ба жилийн 16,8 хувийн хүүтэй, 12 сарын хугацаатай. Уг зээлийн үлдэгдлийг тайлант хугацаанд бүрэн төлж барагдуулсан.

Тайлант хугацаанд шинээр авсан бөгөөд бүрэн хаагдсан зээлүүд

Голомт банкны зээл:

Компани 2020 оны 06 сарын 26-ны өдөр Голомт банктай **ЗГС190005086-4/LNFL** тоот шугаман зээлийн гэрээ байгуулсан. Гэрээний дагуу олгох зээлийн эрхийн хэмжээ 2,000,000.0 мянган төгрөг, зээлийн хүү жилийн 18.6%, зээлийн эх үүсвэр нөөцлөн баталгаажуулсны шимтгэл зээлийн эрхийн ашиглаагүй хэсгийн дүнд жилийн 3.6%-иар тооцох нөхцөлтэй. Уг гэрээний хүрээнд тайлант хугацаанд нийт 6,843,627.7 мянган төгрөгийн зээл авч, түүнийгээ бүрэн төлж барагдуулсанаар тайлант хугацааны эцсийн байдлаар зээлийн үлдэгдэлгүй бөгөөд 2020 оны 12 сарын 10-ны өдөр шугамын эрхийг хаалгасан.

Бичил санхүүгийн хөгжлийн сангийн зээл:

Компани 2020 оны 02 сарын 05-ны өдөр Бичил санхүүгийн хөгжлийн сантай 42/04 тоот дамжуулан зээлдүүлэх гэрээ байгуулсан. Гэрээний дагуу 400,000.0 мянган төгрөгийг 2023 оны 02 сарын 05-ны өдөр хүртэл буюу 3 жилийн хугацаатай, жилийн 10%-н хүүтэйгээр авах байсан ч тайлант хугацаанд 4,500.0 мянган төгрөгийн зээл авч уг зээлээ бүрэн төлж барагдуулсанаар гэрээг дуусгавар болгосон.

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.4. Тодруулга-ИТГЭЛЦЛИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ӨГЛӨГ**

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Итгэлцлийн үйлчилгээний өглөг-хуулийн этгээд	1,534,527.8	1,716,492.7
Итгэлцлийн үйлчилгээний өглөг-хувь хүмүүс	6,552,328.4	4,792,877.3
Дүн	8,086,856.2	6,509,370.0

Итгэлцлийн үйлчилгээний өглөгийг харилцагчтай байгуулсан хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээний дагуу 24 хүртэлх сарын хугацаатайгаар төвлөрүүлсэн ба хорогдуулсан өртгөөр хэмжсэн. Итгэлцлийн үйлчилгээний үр шимийн хувьд итгэмжлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс хамааран харилцан адилгүй бөгөөд жилийн 13.2%-18.0% байна. Гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд итгэлцлийн үр шим жилийн 3.6 хувь болж буурах нөхцөлтэй. Хувь хүмүүст төлөх итгэлцлийн үйлчилгээний өр төлбөрийн дүнд холбоотой талуудад төлөх 1,446,137.9 мянган төгрөгийн өр төлбөр багтсан. Дэлгэрэнгүй үлдэгдлийг тодруулга 6.19-д харуулсан.

6.5. Тодруулга-ХУРИМТЛУУЛЖ ТООЦСОН ХҮҮНИЙ ӨГЛӨГ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Итгэлцлийн үр шимийн өглөг-хуулийн этгээд	112,240.6	101,198.6
Итгэлцлийн үр шимийн өглөг-хувь хүмүүс	364,136.6	243,239.0
Банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүүний өглөг	-	14,621.0
Дүн	476,377.2	359,058.6

Итгэлцлийн үйлчилгээний үр шим нь итгэмжлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс хамааран жилийн 13.2%-18.0% боловч итгэмжлэгч нь хөрөнгө итгэмжлэн удирдах гэрээг хугацаанаас өмнө цуцалсан тохиолдолд үр шим жилийн 3.6 хувь болж буурах нөхцөлтэй. Компанийн удирдлагын зүгээс өмнөх жилүүдийн туршлагадаа үндэслэн хугацаанаас өмнө гэрээ цуцлагдах магадлал маш бага гэж үзэж байгаа тул итгэлцлийн үр шимийн өглөгийг жилийн 13.2-20.0 хувиар тооцож аккруэл сууриар бүртгэсэн. Хувь хүмүүст төлөх итгэлцлийн үр шимийн өглөгийн дүнд холбоотой талуудад төлөх 15,632.7 мянган төгрөгийн өглөг багтсан. Дэлгэрэнгүй үлдэгдлийг тодруулга 6.19-д харуулсан.

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**2020 оны жилийн эцсийн байдлаар дараах санхүүгийн бус хөрөнгө, өр төлбөрүүдийг эзэмшиж байна.**

	Тодруулга	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Санхүүгийн бус хөрөнгө			
Бусад эргэлтийн хөрөнгө	6.6.	190,665.7	293,135.3
Үндсэн хөрөнгө (цэвэр)	6.7.	2,134,959.0	1,911,265.0
Биет бус хөрөнгө (цэвэр)	6.8.	99,484.1	80,391.7
Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	6.9.	684,000.0	684,000.0
Дүн		3,109,108.8	2,968,792.0
Санхүүгийн бус өр төлбөр			
Бусад өр төлбөр	6.10.	377,979.6	207,934.0
Дүн		377,979.6	207,934.0

6.6. Тодруулга-БУСАД ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГӨ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Санхүүгийн бус авлага	50,979.7	7,970.7
Өмчлөх бусад хөрөнгө (цэвэр)	-	-
Урьдчилж төлсөн зардал	89,353.2	238,918.0
Материал үнэ бүхий зүйлс	50,332.8	46,246.6
Дүн	190,665.7	293,135.3

Санхүүгийн бус авлага

Шүүхийн улсын тэмдэгтийн хураамжийн авлага, барьцаа хөрөнгийг гражинд байршуулсан төлбөрийн авлага гэх мэт чанаргүй зээлдэгч нартай холбоотой авлага болон үндсэн үйл ажиллагаатай хамааралгүй авлагыг санхүүгийн бус авлагаар тайлагнасан. Санхүүгийн бус авлагын дүнд холбоотой талуудаас авах 30,000.0 мянган төгрөгийн авлага багтсан.

Өмчлөх бусад хөрөнгө

Өмчлөх бусад хөрөнгө гэдэг нь зээлийн гэрээний үүргээ зөрчиж, зээл, хүүний төлбөрөө төлж барагдуулаагүй зээлдэгчээс зээлийн гэрээний үүргийн дүнд хураан авсан барьцаа хөрөнгө юм. Тайлант хугацаанд 1 харилцагчийн зээл, хүүний авлагын төлбөрт түүний барьцаалсан үл хөдлөх хөрөнгийг хураан авч, борлуулснаар өмчлөх бусад хөрөнгө болон түүний эрсдлийн сан үлдэгдэлгүй болсон.

Урьдчилж төлсөн зардал

Урьдчилж төлсөн зардал нь ажлын байрны түрээсийн урьдчилгаа, программ хангамжийн компанид төлсөн урьдчилгаа болон бусад аж ахуйн үйл ажиллагаатай холбоотой бараа, ажил, үйлчилгээнд урьдчилж төлсөн дүнг илэрхийлнэ.

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан
Санхүүгийн тайлангийн тодруулга

6.7. Тодруулга-ҮНДСЭН ХӨРӨНГӨ

Анхны өртөг (мянган төгрөг):	Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	Нийт
2019.12.31-ний үлдэгдэл	1,554,104.4	161,500.0	267,472.6	105,616.4	2,088,693.4
Худалдан авсан	225,500.0	21,500.0	29,022.0	53,450.9	329,472.9
Капиталжуулсан	57,525.1		330.0		57,525.1
Ангилал хооронд					330.0
Акталж дансаас хассан			1,478.4	1,058.8	2,537.2
Борлуулсан		17,000.0			17,000.0
Ангилал хооронд				330.0	330.0
Алдааны залруулга			228.4	242.0	470.4
2020.12.31-ний үлдэгдэл	1,837,129.5	166,000.0	295,117.8	157,436.5	2,455,683.8

Хуримтлагдсан элэгдэл (мянган төгрөг):

	Барилга, байгууламж	Тээврийн хэрэгсэл	Тавилга эд хогшил	Компьютер, түүний дагалдах хэрэгсэл	Нийт
2019.12.31-ний үлдэгдэл	45,128.3	21,591.7	63,513.2	47,195.3	177,428.5
Нэмж байгуулсан элэгдэл	71,131.7	18,150.0	31,850.5	35,838.0	156,970.2
Ангилал хооронд нэмэгдсэн					
Хасагдсан хөрөнгийн элэгдэл		10,908.3	1,478.4	1,058.8	13,445.5
Алдааны залруулга			228.4		228.4
2020.12.31-ний үлдэгдэл	116,260.0	28,833.3	93,656.8	81,974.5	320,724.7
Үлдэгдэл өртөг:					
2019.12.31-ний үлдэгдэл	1,508,976.2	139,908.3	203,959.4	58,421.1	1,911,265.0
2020.12.31-ний үлдэгдэл	1,720,869.5	137,166.7	201,461.0	75,462.0	2,134,959.1

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING

& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.8. Тодруулга-БИЕТ БУС ХӨРӨНГӨ**

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Программ хангамж	126,533.5	111,700.0
Хуримтлагдсан хорогдол	(41,889.2)	(31,308.3)
Түрээсийн сайжруулалт	16,188.9	
Хуримтлагдсан хорогдол	(1,349.1)	
Үлдэгдэл өртөг	99,484.1	80,391.7

Биет бус хөрөнгө нь компанийн үндсэн үйл ажиллагаа, санхүү, НББ-д ашиглаж байгаа санхүүгийн программын өртөг, хуримтлагдсан хорогдуулалтын дүнг илэрхийлнэ. Тайлангийн хугацаанд төрийн мэдээллийн санд холбогдох ХУР систем болон зээл төлөлтийн гүйлгээг санхүүгийн программд автоматаар оруулах СОТ интерфейс системийн программыг тус тус худалдан авсан.

Түрээсийн сайжруулалт нь тайлант хугацаанд Хан-Уул дүүрэг дэх салбарын түрээсийн оффист хийсэн капитал засварын дүнг илэрхийлнэ.

6.9. Тодруулга-ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЗОРИУЛАЛТТАЙ ҮЛ ХӨДЛӨХ ХӨРӨНГӨ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Амины орон сууц, эзэмших эрхтэй газар	684,000.0	684,000.0
Дүн	684,000.0	684,000.0

Компани Баянгол дүүргийн 6-р хороонд Ү-2205017055 улсын бүртгэлийн дугаартай 720 кв амины орон сууц болон 540 кв талбайтай газрыг эзэмшдэг бөгөөд орлого олох зорилгоор түрээслүүлдэг. ХОЗҮХХ-ийн бодит үнэ цэнийг компани дотооддоо тодорхойлж дансны үнээс материаллаг зөрүүгүй гэж үзсэн.

6.10. Тодруулга-САНХҮҮГИЙН БУС ӨР ТӨЛБӨР

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Цалингийн тооцооны өглөг	4,599.6	34,161.2
ААНОАТ-ын тооцоо	250,139.6	125,569.9
ХХОАТ-ын тооцоо	59,250.4	31,100.2
НДШ-ийн өглөг	8,649.2	
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	8,536.2	
Бусад өр төлбөр	46,804.5	17,102.6
Дүн	377,979.5	207,934.0

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.11. Тодруулга-ӨӨРИЙН ХӨРӨНГӨ**

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Энгийн хувьцаа	2,500,000.0	2,500,000.0
Нэмж төлөгдсөн капитал	684,000.0	684,000.0
Нийгмийн хөгжлийн сан	30,990.9	25,244.7
Хуримтлагдсан ашиг	22,747,259.0	18,392,723.1
Дүн	25,962,249.9	21,601,967.8

Компанийн дүрмийн сан нь нэг бүр нь 1,000,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 2,500 ширхэг хувьцаанаас бүрдэж байна. Тайлангийн хугацаанд хувьцаа эзэмшигчийн бүрэлдэхүүнд өөрчлөлт ороогүй.

Нэмж төлөгдсөн капитал нь компанийн хувьцаа эзэмшигчээс 2012 онд компанид нэмж оруулсан Баянгол дүүргийн 6-р хороо дахь 720 кв амины орон сууц болон 540 кв газрын дүнг илэрхийлнэ.

6.12. Тодруулга- ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ОРЛОГО

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Зээлийн хүүний орлого	8,295,179.2	8,659,432.6
Харилцах дансны хүүний орлого	930.6	2,455.4
Хадгаламжийн хүүний орлого	77,705.7	-
Нэмэгдүүлсэн хүүний орлого	95,743.9	25,381.6
Зээлийн хүүний орлогын буцаалт	(12,986.6)	(558,244.2)
Дүн	8,456,572.8	8,129,025.4

6.13. Тодруулга- ХҮҮ БОЛОН ТҮҮНТЭЙ АДИЛТГАХ ЗАРДАЛ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Зээлийн хүүний зардал	347,871.2	707,288.2
Дүн	347,871.2	707,288.2

Зээлийн хүүний зардал нь банк санхүүгийн байгууллагаас авсан зээлийн хүү болон зээлийн эх үүсвэр нөөцлөн баталгаажуулсны шимтгэлийн дүнгээс бүрдэнэ.

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.14. Тодруулга- ХҮҮНИЙ БУС ОРЛОГО**

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Гадаад валютын ханшийн зөрүүний ашиг	379.5	436.2
Шимтгэл хураамжийн орлого	65,788.6	85,660.9
Зээлийн эрсдлийн сангийн бууралтын орлого	67,526.2	28,350.3
Дүн	133,694.4	114,447.4

6.15. Тодруулга- ХҮҮНИЙ БУС ЗАРДАЛ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Гадаад валютын ханшийн зөрүүний алдагдал	611.3	209.1
Ажиллагсадтай холбоотой зардал	979,677.9	897,190.7
Үйл ажиллагааны бусад зардал	1,884,400.9	1,628,647.7
Эрсдэлийн сангийн зардал	646,870.6	810,188.8
Дүн	3,511,560.7	3,336,236.3

Ажиллагсадтай холбоотой зардал:

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Үндсэн ба нэмэгдэл цалингийн зардал	838,290.2	772,736.9
Нийгмийн даатгалын шимтгэлийн зардал	107,045.3	97,529.7
Ажиллагсадтай холбоотой бусад зардал	34,342.4	26,924.1
Дүн	979,677.9	897,190.7

**“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL**

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.15. Тодруулга- ХҮҮНИЙ БУС ЗАРДАЛ (үргэлжлэл)***Үйл ажиллагааны бусад зардал*

Үзүүлэлт	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Зээл болон түүнтэй холбоотой авлагыг барагдуулахтай холбоотой зардал	5,472.3	149.0
Итгэлцлийн үйлчилгээний үр шимийн зардал	1,240,042.6	1,033,045.8
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	24,079.8	20,724.8
Аудит мэргэжлийн үйлчилгээний хөлс	29,047.0	24,422.7
Даатгалын зардал	3,260.2	2,774.0
Түрээсийн зардал	94,806.4	98,065.4
Ашиглалтын зардал	33,736.8	30,310.9
Элэгдэл, хорогдлын зардал	168,900.1	123,013.5
Менежментийн үйлчилгээний зардал		73,862.5
Шуудан холбооны зардал	23,353.4	14,443.4
Тээвэр, шатахууны зардал	6,708.0	9,608.4
Сэлбэг хэрэгсэл, засварын зардал	16,142.6	17,940.8
Зохицуулалтын үйлчилгээний хураамж	3,240.0	3,240.0
Зар сурталчилгаа, маркетингийн зардал	83,796.0	83,027.5
Бичиг хэргийн зардал	10,102.0	11,068.3
Хангамжийн зардал	9,057.9	5,937.9
Автоматжуулалтын зардал	112,149.5	39,564.3
Бусад зардал	20,506.4	37,448.5
Дүн	1,884,400.9	1,628,647.7

Эрсдэлийн сангийн зардал

Үзүүлэлт	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Зээлийн эрсдэлийн сангийн зардал	646,870.6	810,188.8
Дүн	646,870.6	810,188.8

Зээлийн эрсдэлийн санг байгуулсан аргачлалын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү тайлангийн тодруулга **4.6**, **5.3** болон **6.2**-с харна уу.

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга

6.16. Тодруулга-ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО, ЗАРДАЛ

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
<i>Үйл ажиллагааны бус орлого</i>		
Хөрөнгө борлуулсны олз	37,000.0	141.7
Түрээс болон бусад орлого	42,820.3	44,544.6
ЗГ-ын буцалтгүй тусламж, туслалцааны орлого	55,949.9	
Дүн	135,770.2	44,686.3
<i>Үйл ажиллагааны бус зардал</i>		
Хөрөнгө данснаас хассаны гарз	1,091.7	
Зочид төлөөлөгчийн зардал		1,017.2
Хандив тусламжийн зардал	5,669.0	
Бусад зардал		2,701.6
Дүн	6,760.7	3,718.8
Үйл ажиллагааны бус ашиг (алдагдал)	129,009.5	40,967.5

6.17. Тодруулга-ОРЛОГЫН ТАТВАРЫН ТООЦОО

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Татвар төлөхийн өмнөх ашиг	4,859,844.8	4,240,915.8
Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардал	12,016.8	3,718.8
Бусад байнгын зөрүүгийн нэмэгдүүлэх дүн	78,000.0	
Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын дүн	(115,368.5)	
Бусад байнгын зөрүүгийн бууруулах дүн	(27,360.0)	(32,604.3)
Байнгын зөрүүгээр зохицуулсан татвар ногдуулах орлого	4,807,133.0	4,212,030.2
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус олз		(227.7)
Гадаад валютын ханшийн зөрүүний бодит бус гарз	193.3	
Татвар ногдуулах орлого	4,807,326.3	4,211,802.5
Орлогын татварын зардал	480,769.5	602,950.6

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль шинэчлэгдэж 2020 оны 1 сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан тайлант үеийн ААНОАТ-ыг 10 хувиар ногдуулсан.

6.18. Тодруулга-НЭГЖ ХУВЬЦААНД НОГДОХ СУУРЬ АШИГ

	Хэмжих нэгж	2020.12.31	2019.12.31
Тайлант хугацааны цэвэр ашиг	мянган төгрөг	4,379,075.3	3,637,965.2
Энгийн хувьцааны жинлэсэн дундаж тоо	ширхэг	2,500	2,500
Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг	төгрөг	1,751,630.1	1,455,186.0

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.19. Тодруулга-ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ**

Хэрэв компани нөгөө этгээдийн санхүүгийн болон бусад үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргалтанд шууд ба шууд бусаар нөлөө үзүүлэх буюу хянах чадвартай бол тухайн компанийн хувьд холбоотой тал болох ба хэрвээ тухайн компани нь өөр этгээдийн удирдлага хяналт дор байдаг эсвэл дээр дурдсан харьцаа нь эсрэгээрээ байх тохиолдолд санхүүгийн тайлан бэлтгэх зорилгоор холбоотой талууд гэж тодорхойлдог.

“Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай” хуулиар ББСБ-ын хувьцаа эзэмшигч, ТУЗ-ийн дарга, гишүүд, гүйцэтгэх захирал, бусад ажилтан болон Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2-т заасан этгээдүүдийг холбоотой тал гэж үздэг.

Тус компанийн хувьд доорх этгээдүүд холбоотой талууд байна.

Холбоотой тал	Бизнесийн үйл ажиллагаа	Холбоо хамаарал
Т.Гантөмөр		Хувьцаа эзэмшигч
Очир Ундраа ХХК	Уул уурхай, Барилга, Уул уурхайн тэсрэх материалын худалдаа	Зэргэлдээ компани
Мера ХХК	Уул уурхайн тэсрэх материалын үйлдвэрлэл, худалдаа	Зэргэлдээ компани
Огоот ХХК	Ачаа тээвэр	Зэргэлдээ компани
Бүтээгч ХХК	Барилга угсралт	Зэргэлдээ компани
Бласттек ХХК	Тоног төхөөрөмжийн түрээс	Зэргэлдээ компани
Өү Юу Жи ХХК	Барилга угсралт	Зэргэлдээ компани
Эколожикал	Гадаад, дотоод худалдаа	Зэргэлдээ компани
Текнологи ХХК		
Практикал даатгал	Даатгал	Зэргэлдээ компани
Интелликом ХХК	Тоног төхөөрөмжийн түрээс	Зэргэлдээ компани
Өсөлт ХХК		Зэргэлдээ компани
Д.Энхтуул		ТУЗ-ийн дарга
Д.Даваасамбуу		ТУЗ-ийн гишүүн
Ж.Отгонсүх		ТУЗ-ийн гишүүн
П.Энхбаяр		ТУЗ-ийн гишүүн
Б.Бямбасайхан		ТУЗ-ийн гишүүн
Г.Цогтгэрэл		Гүйцэтгэх удирдлага
Компанийн ажилчид		
Бусад хувь хүмүүс		Хувьцаа эзэмшигчийн гэр бүл

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.19. Тодруулга-ХОЛБООТОЙ ТАЛУУДЫН АЖИЛ ГҮЙЛГЭЭ (үргэлжлэл)****Холбоотой талуудын авлага, өглөгийн тооцоо дараах байдлаар илэрхийлэгдэнэ:**

Үзүүлэлт	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Зээл, зээлийн хүүний авлага:		
Очир-Ундраа ХХК	501,084.9	1,420,573.8
Мера ХХК		1,496,798.9
Бласттек ХХК		-
Огоот ХХК	91,299.9	151,994.4
Бүтээгч ХХК	864,372.6	1,516,635.6
Экологикал техноложи ХХК	653,761.1	848,055.9
Г.Цогтгэрэл	62,537.1	52,733.5
Д.Энхтуул	16,303.6	11,373.0
П.Энхбаяр	28,169.0	7,180.2
Ж.Отгонсүх	18,585.9	
Б.Бямбасайхан		527.1
Ажилчид	84,489.3	23,379.7
Хувьцаа эзэмшигчийн ойрын гэр бүлийн гишүүд	16,135.2	29,322.8
Санхүүгийн бус авлага:		
Т.Гантөмөр	30,000.0	
Дүн	2,366,738.7	5,558,575.0
Итгэлцлийн үйлчилгээний өглөг, түүний үр шимийн өглөг		
Г.Бүжин	21,391.8	18,575.5
Г.Батжаргал	14,040.0	32,772.4
Г.Хатантөмөр	18,723.3	25,704.3
Г.Ундрэм		127.2
Г.Тэгшбуянт	8,918.4	7,744.3
Г.Энхжин		-
Б.Бямбасайхан		12,176.9
Н.Жадамба	1,332,077.0	940,100.8
Н.Оюунтуяа	27,218.0	30,817.8
С.Насан-Урт	27,782.9	29,614.5
Б.Хүрэлпүрэв	11,344.0	238,015.7
П.Энхбаяр	275.0	
Дүн	1,461,770.4	1,335,649.4

ТУЗ-ийн гишүүн Н.Жадамба 2020 оны 9 сард ТУЗ-ийн гишүүний үүрэгт ажлаас чөлөөлөгдсөнөөр холбоотой талын бүрэлдэхүүнээс хасагдсан. Тайлангийн хугацаанд ТУЗ-ийн гишүүдэд 59,150.0 мянган төгрөгийн, гүйцэтгэх удирдлагад 75,264.3 мянган төгрөгийн цалин тус тус тооцож олгосон.

Мөн тайлангийн хугацаанд холбоотой талуудад олгосон зээлээс 1,875,235.2 мянган төгрөгийн хүүний орлого тооцсон ба холбоотой талуудаас татсан итгэлцэлд 218,541.9 мянган төгрөгийн үр шимийн зардал тооцсон байна.

**“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL**

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга

6.20.Тодруулга-БОЛЗОШГҮЙ ЗҮЙЛ

Болзошгүй зүйлсэд тайлангийн хугацаанд эрх, үүрэг нь үүссэн хараахан хэрэгжээгүй байгаа буюу үнийн дүн эсвэл цаг хугацааны хувьд тодорхой бус байгаа зүйлсийг багтаасан ба дараах зүйлсийг тодруулж байна.

- Тайлангийн хугацааны эцсээр 453 харилцагчид 576,200.0 мянган төгрөг (2019 он: 35 харилцагчид 58,400.0 мянган төгрөг)-ийн кредит карт буюу зээлийн эрх нээсэн. Нээсэн эрхээс ашиглагдаагүй үлдэгдэл 191,063.3 мянган төгрөг байна.
- 2020 оны жилийн эцсийн байдлаар нэр бүхий 3 харилцагчид нийт 650,000.0 мянган төгрөгийн шугамын зээлийн эрх нээсэн байгаа. Зээлийн эрхээс ашиглагдаагүй үлдэгдэл байхгүй.
- 2020 оны жилийн эцсийн байдлаар тэнцлийн гадуур бүртгэлтэй зээл, зээлийн хүүний авлагын дүн 1,996,415.8 мянган төгрөг байна.

Өнгөрсөн үйл явдлын үр дүнд хүлээсэн ямар нэг үүсмэл үүрэг хариуцлага байхгүй.

6.21.Тодруулга-БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ

Энэхүү тайланг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болгон 2021 оны 2 сарын 4-ний өдөр бэлтгэсэн ба санхүүгийн тайлан тасалбар болгосноос хойш санхүүгийн тайланд нөлөөлөхүйц үйл явдал гараагүй байна.

6.22.Тодруулга-ТЭНЦЛИЙН ГАДУУРХ ҮЛДЭГДЭЛ

Компани харилцагчдад олгосон зээлийн барьцаа хөрөнгүүд, эрсдлийн сангаас хаасан зээл, хуримтлуулж тооцохыг зогсоосон хүү зэргийг тэнцлийн гадуур бүртгэдэг. 2020 оны жилийн эцсийн байдлаар 145,386.3 мянган төгрөгийн зээл, 1,851,029.5 мянган төгрөгийн хуримтлуулж тооцсон хүү тэнцлийн гадуур бүртгэлтэй байна. Доорх хүснэгтэн мэдээлэл нь тэнцлийн гадуур бүртгэлтэй барьцаа хөрөнгийг үнийн дүнгээр илэрхийлнэ.

Үзүүлэлт	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Орон сууц, объект, бусад үл хөдлөх хөрөнгө	15,520,031.4	16,820,564.7
Хашаа байшингаас бусад багц барьцаа	10,684,906.8	
Газар, хашаа байшин	3,726,470.0	3,457,137.5
Тээврийн хэрэгсэл	13,839,654.4	15,947,760.0
Итгэлцэл	6,967.8	363,535.3
Цалингийн орлого	1,221,800.0	1,537,100.0
Борлуулалтын орлого	20,469,490.0	12,183,450.0
Бараа материал	643,751.9	473,089.1
Дүн	66,113,072.3	50,782,636.6

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

6.23.Тодруулга-ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд бусад бизнесүүдийн нэгэн адил санхүүгийн болон үйл ажиллагааны, хууль зүйн эрсдэлүүд хамаардаг ба эдгээрийг зохицуулагч байгууллагаас тогтоосон эрсдэлийн хязгаарыг барих, эрсдэлийн нөлөөлөлд дүн шинжилгээ хийх, хяналт тавих замаар эрсдэлээ удирдана.

Тайлангийн энэ хэсэгт удирдлагаас эрсдэлийг хянахад ашиглах аргуудыг тодруулсан. Үүнд дараах эрсдэлүүд багтана.

- а) Зээлийн эрсдэл
- б) Төлбөрийн чадварын эрсдэл
- в) Зах зээлийн эрсдэл
 - Хүүний түвшний эрсдэл
 - Гадаад валютын ханшийн эрсдэл
 - Бодит үнэ цэнийн эрсдэл

а) Зээлийн эрсдэл

Зээлийн эрсдэл гэж харилцагч гэрээгээр хүлээсэн төлбөрийн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас хүлээх эрсдэл юм. Зээлийн эрсдэлтэй дүн нь санхүүгийн байдлын тайлан дахь дансны үнээр илэрхийлэгдэнэ.

Зээлийн эрсдэлээс сэргийлэх гол бодлого нь зээлийн барьцаа хөрөнгө байдаг ба зээлийн эрсдэлд өртөж болох санхүүгийн хөрөнгийн хэмжээг доорх хүснэгтэн мэдээлэл харуулна.

Үзүүлэлт	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Харилцагчдад олгосон зээл	22,737,538.7	29,761,611.6
Зохицуулагч байгууллагаас тогтоосон шалгуурын дагуу тооцсон эрсдэлийн сан	(1,617,978.2)	(1,038,633.8)
Цэвэр зээл	21,119,560.5	28,722,977.8

Барьцаа хөрөнгийн үнэлгээг компани дотооддоо үнэлдэг бөгөөд зээл бүтээгдэхүүний төрөл, барьцаа хөрөнгийн чанар байдал, зээлдэгчээс хамааруулан барьцаа хөрөнгийн үнэлгээний 15.0%-иас 100%-тай тэнцэх хэмжээний зээл олгодог. Мөн зээлийн багцад эзлэх чанаргүй зээлийн хэмжээг хамгийн боломжит бага түвшинд (зээлийн багцад 5%-иас хэтрэхгүй) барих бодлогыг баримталдаг.

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга**6.23.Тодруулга-ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)****а) Зээлийн эрсдэл (үргэлжлэл)**

ББСБ нь зээлийн эрсдэлийг барьцаа хөрөнгөөс гадна зохицуулагч байгууллагаас тогтоосон шаардлагын хязгаарт нийцүүлэн зээлийн төвлөрлөөр удирддаг. Үүнд дараах шалгуурууд хамаарна.

	2020.12.31 мянган төгрөг	Өөрийн хөрөнгөнд эзлэх хувь Гүйцэтгэл	Шалгуур
Нэг зээлдэгчид олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив, төлбөрийн баталгааны дээд хэмжээ	2,095,000.0	8.1%	30.0%-иас хэтрэхгүй
Холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив, төлбөрийн баталгааны нийт дүн	2,264,948.4	8.7%	25.0%-иас хэтрэхгүй
Холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив, төлбөрийн баталгааны дүн (нэг харилцагчид)	800,000.0	3.1%	10.0%-иас хэтрэхгүй

б) Төлбөрийн чадварын эрсдэл

Төлбөрийн чадварын эрсдэл гэдэг нь өрийн хэрэглүүрийн эргэн төлөлтөөс үүсдэг эрсдэл юм. ББСБ эргэн төлөлт ба санхүүжилтийн хэрэгцээ хангагдаж байгаа эсэхийг баталгаажуулахын тулд өөрийн үйл ажиллагааны мөнгөн урсгал, санхүүжилтийг идэвхтэй удирддаг.

Төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг зохицуулагч байгууллагаас батласан ББСБ-ын үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тооцож, хяналт тавих журмын дагуу түргэн борлогдох активын дүнг бусдаас татан төвлөрүүлсэн богино хугацаат хөрөнгийн дүнд харьцуулах замаар тооцно.

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Санхүүгийн хөрөнгө		
Түргэн борлогдох хөрөнгө	9,396,151.2	1,210,084.9
Бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгө	8,941,213.0	11,217,151.4
Төлбөр түргэн гүйцэтгэх чадвар	<u>105.1%</u>	<u>10.8%</u>
Зохистой харьцаа	<u>8%-иас дээш</u>	<u>8%-иас дээш</u>

“BAKER TILLY DALAIVAN AUDIT” LLC
CERTIFIED ACCOUNTING, AUDITING
& APPRAISAL

“ОЧИР УНДРАА ОМЗ ББСБ” ХХК

2020 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон жилийн санхүүгийн тайлан

Санхүүгийн тайлангийн тодруулга

6.23.Тодруулга-ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

с) Зах зээлийн эрсдэл (хүүний түвшний эрсдэл)

Хүүний түвшний эрсдэл гэдэг нь зах зээл дээрх хүүний түвшний өөрчлөлтийн улмаас санхүүгийн хэрэглүүрийн бодит үнэ цэнэ эсвэл ирээдүйд гарах мөнгөн гүйлгээний хэлбэлзэх эрсдэл юм. Хүүний түвшний эрсдэлийг зах зээл дээрх хамгийн боломжит хүүний түвшнийг баримтлах замаар удирддаг ба арилжааны банкин дахь богино хугацаат хадгаламж, харилцагч нарт олгосон зээл болон бусдаас татсан эх үүсвэрийн зээлийн хүүний түвшнийг доорх хүснэгтэн мэдээлэл харуулна.

	2020.12.31		2019.12.31	
	мянган төгрөг	Хүүний түвшин сараар	мянган төгрөг	Хүүний түвшин сараар
Мөнгөн хадгаламж				
Хаан банк-1	4,140,000.0	0.63%		
Хаан банк-2	255,910.6	0.58%		
Голомт банк	1,400,000.0	0.6%		
Кредит банк	1,440,000.0	1.16%		
Тээвэр хөгжлийн банк	1,500,000.0	1.16%		
Дүн	8,735,910.6		-	
Харилцагчдад олгосон зээл				
Эргэлтийн хөрөнгө барьцаалсан зээл	4,234,998.0	2.2%-2.9%	10,634,998.2	2.2%
БСХС-ийн төслийн зээл	17,177.7	2.0%	132,841.4	2.0%
Итгэлцэл барьцаалсан зээл	42,499.3	2.2%-2.4%	74,000.0	2.4%-2.5%
Монгол шошго зорилтот зээл			421.6	1.0%
Цалингийн зээл	435,718.6	1.0%-5.0%	463,410.4	1.0%-1.9%
Автолизингийн зээл	5,064,417.6	2.5%-3.5%	6,048,791.9	2.5%-3.3%
Автомашин унаж явах нөхцөлтэй зээл	1,873,177.9	2.2%-3.7%	1,502,273.7	3.0%-3.7%
Автомашин хадгалах нөхцөлтэй зээл	248,197.5	3.0%	540,240.9	3.0%
Орон сууц барьцаалсан шуурхай зээл	478,897.0	2.99%-3.7%	661,489.1	3.3%-3.7%
Орон сууц, объект барьцаалсан судалгаатай зээл	8,184,581.8	2.5%-3.5%	8,154,117.3	2.8%-3.5%
Сургалтын зээл			648.1	3.9%
Хашаа байшин барьцаалсан зээл	918,962.8	2.7%-3.5%	929,305.7	2.8%-3.5%
Хялбар зээл	113,964.7	3.0%-5%	172,807.1	3.5%-5.0%
Шугамын зээл	649,952.6	3.0%	399,995.1	3.0%-3.2%
Кредит картын зээл	372,655.6	2.0%-4.5%	14,067.1	2.0%-4.5%
Автомашинны гаалийн бичиг барьцаалсан зээл	99,908.4	2.7%	23,995.6	3.5%
Газар барьцаалсан зээл	2,429.4	3.7%	8,208.3	3.7%
Дүн	22,737,538.7		29,761,611.6	
Бусдаас татсан эх үүсвэр				
Голомт банк зээл-1			620,000.0	1.5
Голомт банк зээл-2			3,600,000.0	1.58
Капитрон банкны овердрафт зээл			180,765.5	1.4
БСХС-ийн зээл			210,000.0	0.54
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	8,086,856.2	1.1-1.5%	6,509,370.0	1.2-1.67
Дүн	8,086,856.2		11,120,135.5	

6.23.Тодруулга-ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА (үргэлжлэл)

с) Зах зээлийн эрсдэл (гадаад валютын ханшийн эрсдэл)

Гадаад валютын эрсдэл гэдэг нь төгрөгөөс бусад валютаар илэрхийлэгдсэн ажил гүйлгээний ханшийн өөрчлөлтөөс үүсэх санхүүгийн хүндрэл юм. Эрсдэлд өртөж болох гол валют нь Ам.доллар байна.

Гадаад валютын ханшийн эрсдэлээс компани зэх зээл дээрх хамгийн боломжит ханшийг баримтлан удирдах, зохицуулагч байгууллагаас тогтоосон шалгуурын дагуу тэнцлийн болон тэнцлийн гадуурх дансанд бүртгэлтэй нийт гадаад валютын актив пассивын зөрүүг өөрийн хөрөнгөнд харьцуулсан харьцаагаар хянадаг.

Гадаад валютаарх актив пассивын цэвэр зөрүү өөрийн хөрөнгийн +/-40 хувиас хэтрэхгүй байхаар журамласан. 2020 оны жилийн эцсийн байдлаар 146.25 ам доллар, 43.59 евро буюу Монгол банкны хаалтын ханшаар тэгшитгэн тооцвол 569.1 мянган төгрөгийн мөнгөн хөрөнгөөс өөр гадаад валютаар илэрхийлэгдсэн хөрөнгө өр төлбөр, тэнцлийн гадуурх үүрэг хариуцлага байхгүй байна. Өөрийн хөрөнгийн дүн 25,962,249.9 мянган төгрөг байна.

с) Зах зээлийн эрсдэл (бодит үнэ цэнийн эрсдэл)

Бодит үнэ цэнийн эрсдэл гэдэг нь зах зээлд оролцогчдын хоорондын (холбоогүй талуудын) арилжаагаар хөрөнгийг худалдах, худалдан авах үнэ ханшийн өөрчлөлтөөс үүсэх эрсдэл юм.

2020 оны жилийн эцсийн байдлаар бодит үнэ цэнийн эрсдэлд өртөх санхүүгийн хөрөнгө байхгүй. Харин бодит үнэ цэнийн эрсдэлд өртөж болох санхүүгийн бус хөрөнгө нь ХОЗҮХХ байна. Тайлбарыг тодруулга 6.9-д харуулсан.

Эрсдлийн удирдлагатай холбоотой дээрх шалгуураас гадна доорх шалгуур үзүүлэлтүүдээр үйл ажиллагаагаа давхар хянадаг.

Үндсэн хөрөнгө, нийт активын зохистой харьцаа:

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Цэвэршүүлсэн үндсэн хөрөнгө	2,134,959.1	1,911,265.0
Нийт актив	34,903,462.9	33,289,096.0
Нийт активт эзлэх хувь	<u>6.1%</u>	<u>5.7%</u>
Зохистой харьцаа	<u>15%-иас доош</u>	<u>15%-иас доош</u>

Итгэлцлийн үйлчилгээний өр төлбөр, өөрийн хөрөнгийн зохистой харьцаа:

	2020.12.31 мянган төгрөг	2019.12.31 мянган төгрөг
Итгэлцлийн үйлчилгээний өглөг	8,086,856.2	6,509,370.0
Өөрийн хөрөнгө	25,962,249.9	21,601,967.8
Нийт активт эзлэх хувь	<u>31.1%</u>	<u>30.1%</u>
Зохистой харьцаа	<u>80%-иас доош</u>	<u>80%-иас доош</u>

6.24. БУСАД МЭДЭЭЛЭЛ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 2018 оны 04 сарын 26-ны өдрийн нэмэлт өөрчлөлт, Монгол банк болон Санхүүгийн зохицуулах хорооны хамтран баталсан “Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам”-ыг тус тус үндэслэн компанийн гүйцэтгэх захирлын 2018 оны 11 сарын 30-ны өдрийн А-18/43 тоот тушаалаар мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хөтөлбөр болон журмаа шинэчлэн баталсан. Уг журам болон хөтөлбөрийн хэрэгжилтийг дотоод хяналт, эрсдлийн менежер М.Оюун-Эрдэнэ хариуцан ажилладаг.

Аудитын тайланг, тодруулгын хамт англи, монгол хэлээр тус бүр дөрвөн эх хувь бэлтгэсэн бөгөөд хуулбар болон англи тайланд утгын зөрүү гарвал монгол эх хувийг баримтлах болно.

6.25. ЗЭРЭГЦҮҮЛСЭН МЭДЭЭЛЭЛ

Үйлчлүүлэгчийн санхүүгийн тайлангаар илэрхийлэгдсэн дүнг эдгээр санхүүгийн тайлантай нийцүүлэх зорилгоор өмнөх оны зарим мэдээллийг дахин ангилсан болно.


"БЭЙКЕР ТИЛЦИ ДАЛАЙВАН АУДИТ" ХХК
УЛААНБААТАР ХОТ
МОНГОЛ УЛС

2021 ОНЫ 02 ДУГААР
САРЫН 04-НИЙ ӨДӨР